

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР  
ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2023 оны 01 дүгээр  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны Салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, зааврын хэрэгжилтийг системийн хэмжээнд хангах, түүнд хяналт тавих, төрийн алба хаагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалахад үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

**Нэг. Ерөнхий хэсэг.**

**1.1. Салбар зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа, төлөвлөгөө, зохион байгуулалтын ажил, үр дүн**

Тус зөвлөл нь ШШГБ-ын хэмжээнд 2022 оныг “Цахимжуулалт, шинэ сэргэлт”-ийн жил болгох зорилт, Төрийн албаны тухай хууль, холбогдох журам, заавар болон Төрийн албаны зөвлөлийн бодлого, шийдвэрт нийцүүлэн Салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны 4 үндсэн арга хэмжээний хүрээнд 24 ажил, үйлчилгээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр батлан ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн бодлого, шийдвэр, тогтоол, журам, заавар, байгууллагын Салбар зөвлөлийн үйл ажиллагаа, хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудал, хүний нөөцтэй холбоотой асуудлаар алба хаагчдад мэдээлэл хийж, ажлын байрны сул орон тооны зарыг байгууллагын вэб сайтад байршуулсан.

Салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, мэдээ судалгааг гарган, 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/52 дугаар албан бичгээр, 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 01/1531 дүгээр албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ШШГЕГ-ын веб хуудаст байрлуулан, бие бүрэлдэхүүн болон үйлчлүүлэгч-иргэдэд мэдээлэн сурталчилсан нь ил тод, нээлттэй байдлыг хангах нэг гол арга хэмжээ боллоо.

Байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцсэн хүний нөөцийг бэлтгэх, бэлтгэгдсэн хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх давтан болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, мөн алба хаагчдын боловсролын түвшинг нэмэгдүүлэх зорилгоор гадаадын болон дотоодын их, дээд сургууль, удирдлагын академид элсэн суралцуулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 2022 оны эхний хагас жилд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

**Албаны сургалтын талаар:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/218 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2022 онд зохион байгуулах сургалтын хөтөлбөр”-ийг

батлуулан, нийт анги, байгууллагуудад хүргүүлж, сар бүр сургалтын тайлан мэдээг авч нэгтгэн, удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан.

2022 онд алба хаагчдад зохион байгуулах сургалтыг танхимын, цахим, мэргэшүүлэх сургалт гэсэн 3 төрлөөр явуулсан.

Албаны сургалтын гүйцэтгэлийн тайланг нэгтгэхэд харьяа анги, байгууллагууд сургалтын хөтөлбөрийн хүрээнд алба хаагч бүрийг хөгжүүлэх, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн **61** цагийн лекц, **135** цагийн семинар, **79** цагийн бие даалт нийт **275** цагийн хичээл сургалтад **56** анги байгууллагын **2350** алба хаагч хамрагдаж, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллалаа.

#### **Алба хаагчдын цахим сургалтын талаар:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдыг үндсэн ажил үүргээс нь хөндийрүүлэлгүйгээр тэдний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг сайжруулах зорилгоор дараах агуулгын хүрээнд сургалт зохион байгуулсан.

Анги байгууллага, салбар нэгжийн цахим сургалтад хамрагдсан алба хаагчдын тоон мэдээллийг тухай бүр авч нэгтгэн, бүртгэл хөтлөн ажилласан.

Нийт 14 удаагийн 28 цагийн хичээл сургалтад анги, байгууллагын 24.450 /давхардсан тоогоор/ алба хаагч цахимаар, 628 /давхардсан тоогоор/ алба хаагч танхимын хэлбэрээр тус тус хамрагдсан.

#### **Төрөл мэргэжлийн алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтын талаар:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/218 дугаар тушаалаар батлагдсан хөтөлбөрт тусгагдсан хуваарийн дагуу дараах төрөл мэргэжлийн алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан. Үүнд:

- ШШГЕГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/06 дугаар тушаалаар хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийн дотоод хяналт шалгалт, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудыг мэргэшүүлэх цахим сургалтыг 2022.01.11-ний өдөр зохион байгуулж, нийт 53 алба хаагч;

- ШШГЕГ-ын даргын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/50 дугаар тушаалаар Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны техник хяналтын ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтыг 2022.03.25-ны өдөр зохион байгуулж, нийт 30 алба хаагч;

- ШШГЕГ-ын даргын 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/63 дугаар тушаалаар хорих анги, байгууллагын нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтыг 2022.03.31-04.01-ний өдрүүдэд зохион байгуулж, нийт 60 алба хаагч;

- ШШГЕГ-ын даргын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/67 дугаар тушаалаар хорих анги, байгууллагын ахлах төлөөлөгч, төлөөлөгч нарыг мэргэшүүлэх сургалтыг 2022.03.31-04.01-ний өдрүүдэд зохион байгуулж, нийт 91 алба хаагч;

- ШШГЕГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/72 дугаар тушаалаар хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, салбар нэгжид шинээр томилогдон ажиллаж байгаа алба хаагчдад байгууллагын үйл ажиллагааны онцлог, цэргийн хэргийн мэдлэг олгох давтан сургалтыг 2022.04.11-ээс 22-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 116 алба хаагч;

- ШШГЕГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/127 дугаар тушаалаар хорих анги, байгууллагын сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтыг 2022.05.26-27-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 118 алба хаагч;

Энэхүү сургалттай холбогдуулан Төрийн албаны зөвлөлд 2022.05.02-ны өдрийн 05/980 дугаар албан бичиг хүргүүлж, 2022.05.27-ны өдөр дараах сургалтыг явуулсан. Үүнд:

- Төрийн албан хаагчийн ёс зүй үндэс,
- Төрийн албаны үнэт зүйл, түүнд суурилсан байгууллагын соёлоо бүтээх нь,
- Төрийн албан хаагчийн ёс зүйтэй шийдвэр гаргалт, нөлөөлөх хүчин зүйл, сорилт,
- Өрөөсгөл хандлага, хэвшмэл ойлголт нь төрийн албан хаагчийн шийдвэр болон харилцаанд нөлөөлөх нь

-ХЯЭА-ны даргын өгсөн үүргийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр нийт хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн хүний тоо бүртгэлийн байцаагч, туслах нарыг мэргэшүүлэх цахим сургалтыг зохион байгуулж, нийт 67 алба хаагч тус тус хамрагдсан.

2022 оны жилийн эцсийн байдлаар төрөл мэргэжлийн алба хаагчдыг мэргэшүүлэх 10 удаагийн модуль сургалтад нийт **1.292** алба хаагч хамрагдсан байна.

#### **Бусад ажлын талаар:**

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт бие бүрэлдэхүүн нэгдэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 100 сая мод тарих хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

2022 оны 05 дугаар сарын 14-ний өдөр “Бүх нийтийн мод тарих өдөр”-ийг тохиолдуулан Таширын аманд хотын бүсийн хорих анги, байгууллагын алба хаагчид нийт 2000 мод тарьж мод тарих хөтөлбөрийн үйл ажиллагааг эхлүүлсэн.

Тус байгууллага нь ХААИС-ын Агроэкологийн сургуультай сургалт зохион байгуулах чиглэлээр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай үрсэлгээ нийлүүлэх болон бусад чиглэлээр хамтран ажиллах гэрээг тус тус байгуулсан.

ШШГЕГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/130 дугаар тушаалаар 100 сая мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн тушаалыг шинэчлэн баталж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 100 сая мод тарих хөтөлбөрийг ШШГЕГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/152 дугаар тушаалаар батлан, анги, байгууллагад хүргүүлсэн.

ХААИС-ийн “Агроэкологийн сургууль”-д ойжуулалтын чиглэлээр алба хаагчдыг 14 хоногийн сургалтад 51 алба хаагч хамруулж, гэрчилгээ олгосон бол хорих ял эдэлж 1170 хоригдлыг “Ойжуулалт”, “Агро-Ойжуулалт”, “Таримлын агротехнологи”, “Усалгаа”, “Бордоо”, “Ургамал хамгаалал”, “Арчилгаа”-ны чиглэлээр цахим сургалтад хамруулжээ.

2022 оны хаврын мод тарилтыг 2022 оны 05 дугаар сарын 14-21-ний өдрүүдэд зохион байгуулж, үрээр 404450, харандаа үрсэлгээгээр 310050, тарьц, суулгацаар 37041, **нийт 751541** ширхэг мод тарьсан.

2022 оны намрын мод тарилтыг 2022 оны 10 дугаар сарын 15-22-ны өдрүүдэд зохион байгуулж, тарьц, суулгацаар 20450, үрийн үрсэлгээгээр 23834, **нийт 75234** ширхэг мод тарьсан бөгөөд өнөөдрийн байдлаар байгууллагын хэмжээнд **826,775** ширхэг мод тариад байна.

100 сая мод тарих стратеги хөтөлбөрийн хүрээнд мод үржүүлгийн газрыг бий болгох зорилгоор 25 хорих анги, орон нутаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжид нийт 58,7 га газарт мод үржүүлгийн орчныг бий болгосон.

Байгууллагын хэмжээнд 20 ширхэг хүлэмжийг байгуулан, агч мод, нарс, шинэс, хайлаас, шар хуайс, монос, голт бор зэрэг модны үрийн үрсэлгээг хийж, цаашид бойжуулах, ургуулах талаар зохих арга хэмжээг авч ажилласан.

- Засгийн газрын “Монгол хэлний хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 07 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны хүрээнд алба хаагчдад монгол бичгийн мэдлэг эзэмшүүлэх анхан шатны сургалтыг эрчимтэй зохион байгуулан, анги байгууллага, салбар нэгж бүр дотооддоо мэргэжлийн багш нартай хамтран монгол бичгийн сургалт зохион байгуулан ажиллаж байна.

## **1.2. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийн хэрэгжилт, хуралдааны тэмдэглэлийг албажуулсан байдал:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл нь батлагдсан “Хуралдааны дэг”, “Ажил үүргийн хуваарь”-ийг мөрдөж байгаа бөгөөд байгууллагын цахим хуудсанд байршуулан иргэд, үйлчлүүлэгчдэд мэдээлэн сурталчилж ажиллаж байна.

Салбар зөвлөл нь хууль, журамд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд тайлангийн хугацаанд нийт 3 удаа хуралдан, удирдах албан тушаалтны томилгоо болон бусад шаардлагатай цаг үеийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн ажилласан.

Хуралдааны хөтөлбөрийг урьдчилан гаргаж батлуулан, хуралдааны тэмдэглэлийг албажуулан, холбогдох материалуудыг нэгж болгон цэгцлэн ажиллаж ирсэн.

Салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, мэдээ судалгааг гарган, 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/52 дугаар албан бичгээр, 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 01/1531 дүгээр албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ШШГЕГ-ын веб хуудаст байршуулсан.

Салбар зөвлөлийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

2021.12.24-ний өдрийн 01/2739 дүгээр албан бичгээр тус газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулах саналыг хүргүүлсэн.

Энэхүү саналтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2022.01.26-ны өдрийн 38, 2022.05.24-ний өдрийн 371, 2022.06.22-ны өдрийн 432, 2022.12.23-ны өдрийн 06/2542 дугаар тогтоолоор албан тушаалаас чөлөөлөгдсөн, албан тушаал өөрчлөгдсөн, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон нэр бүхий алба хаагчдыг салбар зөвлөлийн гишүүнээс чөлөөлүүлж, бүрэлдэхүүнд 6 алба хаагчийг томилуулсан байна.

Тайлангийн хугацаанд Салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл гомдол байхгүй. Төрийн албаны зөвлөлийн 2022.03.14-ний өдрийн "Тогтоол хүргүүлэх тухай" 03/526 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн 2022.02.23-ны өдрийн "Тушаал хүчингүй болгох тухай" Ж.Энхтайванд холбогдох 72 дугаар тогтоолыг ирүүлсэн. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж албан тушаалд томилсон.

Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор батлагдсан журам, зааврыг алба хаагчдад мэдээлэн сурталчилж судлуулах, хүний нөөцийн холбогдолтой асуудлыг шийдвэрлүүлэхээр ШШГЕГ-т уламжлахдаа анхаарах зарим асуудал зэргээр тодорхой үүрэг чиглэлийг анги, нэгжийн удирдлага, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нарт өгч, биелэлтийг хангуулж ажилласан.

#### **Хоёр: Үндсэн хэсэг:**

##### **2.1. Хууль, журам, заавар, төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал, үр дүн**

2022 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа анги, нэгжийн үйл ажиллагаанд төрийн хууль тогтоомжийн хэрэгжилт, алба хаагчдын сахилга, хариуцлага, байгууллагын болон төрийн алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, биелэлт, хүний нөөцийн бодлогын бичиг баримт, хувийн хэргийн бүрдүүлэлт, цахим системийн хөтлөлт зэрэг бүх л талын ажлыг хянан шалгах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хуваарийг батлан мөрдүүлж ажилласан.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хэрэгжиж буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Тухайлбал,

ШШГБ-ын үйл ажиллагаанд 2022 оны хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/2852 дугаар албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

Мөн Засгийн газрын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2022 оны 07-12 дугаар сарууд үнэлгээ хийж төрийн мэдээллийн цахим сүлжээ [www.mojha.unelgee.gov.mn](http://www.mojha.unelgee.gov.mn) - д сар бүр тайлагнасан.

МУ-ыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 100 хувь буюу 5 оноо, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 79 хувь буюу 3.9 оноо, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт 100 хувь буюу 5 оноо, Салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ 100 хувь буюу 5 оноо, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт 96 хувьтай буюу 4.8 оноотой, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 97 хувь буюу 4.8 оноо, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь буюу 5 оноотой тус тус дүгнэгдэж Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнан ажилласан.

ШШГБ-д сүүлийн 5 жилийн хугацаанд /2017-2022 он/ хийгдсэн Үндэсний аудитын газар болон дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн судалгааг нэгтгэн тайланд аудит хийж, аудитын дүгнэлтийг цахим хэлбэрээр ХЗДХЯ-нд тайлагнасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2021, 2022 онуудын эрсдэлийн үнэлгээний тайлан, мэдээллийг "mojha.unelgee.gov.mn" төрийн цахим системд 2022 оны 05, 12 дугаар саруудад байршуулж, тайланг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/2537 дугаар албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Өмнөх онд /2021/ тодорхойлсон эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дотооддоо арилгаж, бууруулах, ангилж, ач холбогдлоор зэрэглэн эрсдэлийг бодитой тогтоох бодлого баримтлан ажиллалаа.

Шилэн дансны тухай хуулийн дагуу [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд ШШГЕГ болон хорих анги, байгууллага нийт 63 нэгжийн байршуулсан мэдээлэлд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт тавихад 3 ангиллын 21 төрлийн 10146 мэдээллийг байршуулахаас 9954 мэдээллийг тогтоосон хугацаанд нь, 192 мэдээллийг хугацаа хоцроож олон нийтэд мэдээлснээр тогтоосон хугацаанд мэдээлэл байршуулах үйл ажиллагаа 99.1 хувьтай байна.

Байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2022 оны аудитын тайланг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 07/2851 дүгээр албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлж ажилласан.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийж, 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 01/2763 дугаар албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

## **2.2. Төрийн жинхэнэ албанд ажиллах хүний нөөцийг сургаж бэлтгэх, нөөц бүрдүүлэх, томилогдох ажилтны сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн сул орон тоог нөхөх, ахлагч бүрэлдэхүүний нөөц бүрдүүлэх зорилгоор ДХИС-ийн Ахлагчийн сургуулийн "харуул хамгаалалтын албаны ажилтан" бэлтгэх дамжааны сургалтыг дараах хугацаанд зохион байгуулан, хүний нөөцийг бүрдүүлсэн. Үүнд:

1. 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсан сургалтад 83 сонсогч;

2. 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулсан сургалтад 74 сонсогч;

3. ШШГЕГ-ын даргын 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/167 дугаар тушаалаар чиглүүлэх богино хугацааны сургалтад 137 иргэн;

4. 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 11 дүгээр сарын 17-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулсан сургалтад 68 сонсогч, нийт **362** иргэнийг тус тус суралцуулан төгсгөсөн.

5. 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс нийт **78** иргэнийг сонгон шалгаруулж, сургалтад хамруулаад байна.

**ДХИС-ийн Ахлагчийн сургуулийн офицер бэлтгэх дамжааны сургалтад:**

1. 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсан сургалтад 21 алба хаагч;

2. 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 12 дугаар сарын 02-ны өдөр хүртэл зохион байгуулсан сургалтад 39 алба хаагч тус тус амжилттай хамрагдаж төгссөн.

Байгууллагын онцлог, үйл ажиллагааг иргэдэд сурталчилан ШШГБ-д ажиллах хүсэлтэй иргэдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр нийт анги байгууллагууд орон нутгийн цэргийн анги, салбарын хугацаат болон гэрээт цэрэг, ЕБС-ийн төгсөх ангийн сурагчидтай уулзалт зохион байгуулж ажилласан.

**Гадаадын их, дээд сургуульд суралцагсдын талаар:**

Хууль зүй, дотоод хэргийн яам, Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд байгууллагын захиалгаар Москва хотын Удирдлагын академийн адъюнктурт 1, магистрантурт 3, Москва хотын их сургуулийн сэтгэл зүйн бакалаврын хөтөлбөрт 5, ОХУ-ын Волгоград хотын их сургуулийн эрх зүйн бакалаврын хөтөлбөрт 2, Санктпетербург хотын академийн сэтгэл зүйн бакалаврын хөтөлбөрт 3, Екатеринбург хотын Уралын их сургуулийн эрх зүйн бакалаврын хөтөлбөрт 2, хэлний бэлтгэлд 4, Воронеж хотын их сургуулийн хэлний бэлтгэлд 2, нийт **22** алба хаагч суралцаж байна.

**Дотоодын их дээд сургуульд суралцагсдын талаар:**

Байгууллагын захиалгаар ДХИС-ийн бакалаврын хөтөлбөрийн өдрийн ангид 140, эчнээ ангид 86, магистрт 29, докторт 8 алба хаагч;

Дотоодын их дээд сургууль болох АШУҮИС-д 4, "Шинэ анагаах ухаан" их сургуульд 1, ШУТИС-ийн "Мэдээлэл, холбооны технологийн сургууль"-д 2, нийт 7 иргэн тус тус суралцаж байна. Суралцагсдын 2021-2022 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийн 50 хувийг байгууллагаас олгож шийдвэрлэсэн.

ДХИС-ийн ШШГАС-ийн бакалаврын эчнээ болон магистр, докторын суралцагчидтай сургалтын гэрээ байгуулан, сургалтын явц, ирцийн мэдээллийг тухай бүр авч хяналт тавин ажилласан.

Өмнөх оны нөөцөд бүртгэлтэй ДХИС-ийн ШШГА-ны сургуулийн 5 сонсогч, Ахлагчийн сургуулийг төгссөн 61, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 44 иргэнээс нөөц бүрдүүлэлтийг зохион байгуулан ажиллаж байна

Хамгаалалтын ажилтны сул орон тоог нөхөх зорилгоор 2022.05.02-ны өдрийн 05/982 дугаар албан бичгээр Зэвсэгт хүчний 015 дугаар анги, 2022.05.02-ны өдрийн


05/981 дүгээр албан бичгээр Зэвсэгт хүчний 017 дугаар ангиудад хамтран ажиллах саналыг хүргүүлсэн.

Эмч, сувилагчийн сул орон тоог нөхөх зорилгоор 2022.05.02-ны өдрийн 05/979 дүгээр албан бичгээр АШУҮИС-ийн Оюутны хөгжил, удирдлагын газарт хамтран ажиллах саналыг хүргүүлж, байгууллагын танилцуулгыг цахим шуудангаар хүргүүлсэн.

Мөн 2022.05.10-ны өдөр Этүгэн их сургуулийн “Хүндэтгэлийн лекц” ажил олгогч аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг өдөрлөгт оролцон төгсөгчдөд ШШГБ-ын талаар танилцуулж, ажилд орохыг хүссэн 83 төгсөгчийн товч анкетыг авч нөөцийн бүртгэлд авсан.

Захиргааны удирдлагын газрын 2022.06.02-ны өдрийн “Үүрэг хүргүүлэх тухай” 05/1255 дугаар албан бичгээр харьяа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хэлтэс, салбар нэгжүүдэд шинээр томилогдсон болон ажиллаж байгаа алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, санал хүсэлтийг сонсох, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарч ажиллах талаар үүрэг хүргүүлсэн. Тус үүргийн биелэлтийг хангах талаар харьяа нэгжүүдийн сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүдэд зааварчилгаа өгч ажиллаж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар хийгдсэн алба хаагчдын шилжилт хөдөлгөөнийг 2021 оны мөн үетэй харьцуулахад ШШГБ-д шинээр томилогдсон алба хаагчийн тоо 50.8 хувиар, тэтгэвэрт гарсан алба хаагчийн тоо 47.4 хувиар, ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн алба хаагчийн тоо 34.5 хувиар, шилжсэн алба хаагчийн тоо 1.5 дахин, дэвшин томилогдсон алба хаагчийн тоо 1.12 дахин, албан тушаал буурсан алба хаагчийн тоо 1.2 дахин өссөн, халагдсан албан хаагчийн тоо 28.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



“Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж удирдлагаас гаргасан алба хаагчийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тушаал, шийдвэр болон холбогдох бусад 59675 хуудас материалыг хувийн хэрэгт баяжилт хийж, шинээр албан тушаалд томилогдсон 287 алба хаагчийн хувийн хэргийг нээн товъёог хөтөлж, харьяа газар, анги, салбар нэгжид байршуулсан.

“Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хууль 2022.05.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Амжилт Дотком” ХХК-тай хамтран ажиллаж алба хаагчдын үнэмлэхийг цагийн бүртгэлтэй хослуулсан байдлаар захиалан хэвлүүлж байна.

Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” арга зүйн сургалтад харьяа алба, хорих анги, газар, салбар нэгжийн алба хаагчдыг тогтмол хамруулах талаар анхааран ажилласан ба нийт 30 удаагийн сургалтад хамруулсан.

Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн хариутай 10 албан бичигт хариуг хүргүүлж ажилласан.

Төрийн алба хаагчдын ажил хөдөлмөрийн үр дүнг үнэлж, сайшаан урамшуулах, зөрчил, дутагдал гаргасан тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг зохих хууль, журмын хүрээнд шийдвэрлэн ажиллаж ирлээ.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагуудын сул орон тоонд иргэнийг судлан зохих албан тушаалд томилох 549, түр орлон гүйцэтгүүлэх 44, жинхлэх 13, албан тушаал дэвшүүлэх 293, албан тушаалд шилжүүлэх 493, өөрийн хүсэлтээр чөлөөлөх 370, эрүүл мэндийн шалтгаанаар түр чөлөөлөх 2, бусад байгууллагын мэдэлд шилжүүлэх 19, цалинтай болон цалингүй чөлөө олгох 32, хүүхэд асрах чөлөө 119, тусламж олгох 17 асуудлыг судалж шийдвэрлэсэн.

Эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл, үр бүтээл гарган ажиллаж байгаа алба хаагчдыг шагнаж урамшуулах, тэдгээрийн ажиллах урам зоригийг өрнүүлж идэвхжүүлэх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, мөн ахмад настнуудад урамшуулал үзүүлэхэд анхаарч ажиллаж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар алба хаагчдын шагнал, урамшууллын байдлыг нэгтгэхэд:

#### ***Шагнал урамшууллын талаар:***

Монгол цэргийн өдөр, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 101 жилийн ой, Улс тунхагласны өдрийг тохиолдуулан ажилласан жил, ажлын үр бүтээлийг харгалзан Төрийн одон, медалиар **181**, Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар **466**, ШШГБ-ын шагналаар, **1301**, нийтдээ **1948** хүн буюу нийт албан хаагчдын 61 хувийг шагнаж урамшуулсан байна.

Мөн ШШГБ-ын 101 жилийн ойг тохиолдуулан Төрийн одон, медалиар **492**, Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар **2**, ШШГБ-ын шагналаар **113** ахмад настныг шагнажээ.

“Цэргийн цол олгох журам”-ын дагуу цэргийн цол хоорондын хугацааг баримтлан тэмдэглэлт баярыг тохиолдуулан харьяа газар, хэлтэс, албадуудаас ирүүлсэн санал, тодорхойлолтыг үндэслэн эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан **636** алба хаагчийг цэргийн ээлжит цол, **52** алба хаагчид хугацааны өмнө цэргийн цол олгож, **52** алба хаагчийн урьд хэрэглэж байсан цолыг сэргээсэн, мөн шинээр **377** алба хаагчид цол олгосон байна.

Тайлангийн хугацаанд **115** алба хаагчийг цэргийн алба хаасны болон хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох асуудлыг шийдвэрлүүлсэн.

Үзүүлэлт	2022 оны жилийн эцсийн байдлаар
Төрийн дээд шагнал	181
Хууль зүй, дотоод хэргийн яамны шагнал	466
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шагнал, цол	1301
<b>Нийт</b>	<b>1948</b>

2022 оны жилийн эцсийн байдлаар ШШГЕГ-ын даргын тушаалаар эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандаж, сахилгын зөрчил гаргасан 64, Хорих анги, Шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийн даргын тушаалаар 385, нийт 449 алба хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан нь нийт алба хаагчдын 14 хувийг эзэлж байна.

**Оногдуулсан сахилгын шийтгэлийн төрлөөр:**

Оногдуулсан сахилгын шийтгэлийн төрөл	ШШГЕГ-ын даргын тушаалаар		Харьцуулалт	Нэгжийн даргын тушаалаар		Харьцуулалт
	2021 оны жилийн эцэс	2022 оны жилийн эцэс		2021 оны жилийн эцэс	2022 оны жилийн эцэс	
Сануулах	21		=	110	133	+20.9%
Албан тушаалын цалингийн хэмжээг бууруулах	19	13	-31.5%	91	134	-47.2%
Цолны мөнгийг 3 сар хүртэл хугацаагаар хасах	11	6	-45.4%	60	118	+96.6%
Цэргийн цолыг бууруулах	16	24	+50%	-	-	-
Албан тушаал бууруулан томилох	7	11	+57.1%	-	-	-
Халах	14	10	-28.5%	-	-	-
<b>НИЙТ ДҮН</b>	<b>88</b>	<b>64</b>	<b>-27.2%</b>	<b>261</b>	<b>385</b>	<b>+47.5%</b>

ШШГЕГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар 2022 оныг “Цахимжуулалт, шинэ сэргэлт”-ийн жил болгон зарласан. Тус зорилтын хүрээнд:

1. Байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэн, цахимжуулах ажлыг эрчимжүүлэх;
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн орчинг шинэчлэн, хэрэгжилтийг хангах;
3. Ногоон хөгжлийг дэмжиж “100 сая мод” хөдөлгөөн өрнүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тогтсон.

2022 оны жилийн эцсийн байдлаар дээрх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**Байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэн, цахимжуулах ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний хүрээнд:**

- Цахим хөгжлийн багц хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Төрийн байгууллагуудын 21 төрлийн сервис мэдээллийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээр дамжуулан авч, тоон гарын үсгийн тусламжтайгаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ашиглах боломжийг бүрдүүлсэн.

- 2022 онд Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын **3246** алба хаагчдад иргэний тоон гарын үсэг олгож, ашиглалтын талаар заавар, зөвлөгөөг тухай бүр өгч сургалт зохион байгуулсан.

Мөн хорих ял эдэлж **662** хоригдолд тоон гарын үсэг олгож, ашиглалтын талаар заавар, зөвлөгөөг өгсөн бөгөөд олголтын ажил цаашид тогтмол үргэлжилж байна.

- Байгууллагын хэмжээнд албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд “Edoc” системийг нэвтрүүлж, нийт **1321** хэрэглэгчийг үүсгэж, байгууллагын хэмжээнд нийт **1123** алба хаагчдад систем ашиглалтын талаар сургалт зохион байгуулсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/239 тоот тушаалаар тус системийг албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд бүрэн ашиглаж эхэлсэн.

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан “Тоон гарын үсгийн дэд бүтэц, ашиглалтыг хангах” сэдэвт сургалтад ШШГЕГ-ын 2, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан “Цахим хөгжлийн багц хуулийг танилцуулах” сэдэвт сургалтанд ШШГЕГ-ын 50, ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан “Цахим хөгжлийн багц хуулийн танилцуулга, онцлог зохицуулалт” сэдэвт сургалтад байгууллагын нийт бие бүрэлдэхүүн цахимаар, тус байгууллагын Мэдээллийн технологийн хэлтсээс 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Цахим хөгжлийн багц хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах нь” сургалтад хорих анги, байгууллагын холбоо, мэдээллийн технологийн 37, E-Mongolia академиас 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдөр ШШГЕГ-ын 167 алба хаагчдад Төрийн мэдээллийн нэгдсэн порталын ашиглалт, хувийн болон байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах талаар сургалтад байгууллагын нийт бие бүрэлдэхүүн тус тус хамрагдсан.

#### Захиргааны үйл ажиллагааны чиглэлээр:

1. Байгууллагын цахим хуудасны шинэчлэлтийг хийж дуусган, туршилтын хэлбэрээр [www.uzesgelen.cd.gov.mn](http://www.uzesgelen.cd.gov.mn) хаягт байршуулж, 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс үндсэн цахим хуудасны срапел-тай холбосон. Мөн нийт хорих анги, байгууллагын **63** цахим хуудсыг шинэчлэн байршуулж, мэдээ, мэдээлэл нийтлэн байршуулах тухай сургалт зохион байгуулсан.

2. Архивын ерөнхий газартай хамтран Төрийн архивын ([www.e-document.gov.mn](http://www.e-document.gov.mn)) системийг Тусгай архивын үйл ажиллагаанд нэвтрүүлж, архивын мэдээллийн сан буюу хуучин цахим программд хадгалагдаж буй хөмрөг, данс, хадгаламжийн нэгжийн цахим хувийг Архивын ерөнхий газрын Мэдээллийн технологийн газарт 2022.11.02-ны өдөр зөөврийн хард дискт хуулбарлан өгч, мэдээллийн системд бүртгүүлсэн.

3. Архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг албаны тоон гарын үсэгтэй уялдуулан харьяа алба, хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжүүдийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилгоор 6 төрлийн албан тушаалын 634 албаны тоон гарын үсэг, е-токен төхөөрөмжийг нэвтрүүлэхэд шаардагдах 33,602,000 төгрөгийн зардал бүхий судалгаа гаргасан.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдыг үндсэн ажил үүргээс нь хөндийрүүлэлгүйгээр тэдний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг сайжруулах зорилгоор **meeting ID: 394 326 3591 Passcode: surgalt222** гэсэн цахим хаяг үүсгэсэн.

5. “Хүний нөөц, хувцас хангалтын программ”-ыг шинэчлэх гүйцэтгэх ажлын даалгаврыг боловсруулж, “Интерактив” ХХК-ийг сонгон шалгаруулж, гэрээг байгуулан систем гүйцэтгэх ажлыг ашиглаж эхэлсэн.

#### Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд:

1. Зорчих эрхийг хязгаарлах ял:

2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр “Бодь Электроникс” ХХК-тай хамтран Цахим хяналт-удирдлагын төвийн зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын системд байршин ажиллаж байгаа сервер тоног төхөөрөмжийн системийн өгөгдлийн бааз болон үндсэн хяналтын программ хангамжийн ажиллах орчинг сайжруулсан.

Тус системд холбогдон ажиллаж байгаа цахим бугуйвчийг дахин ачааллуулж, программ хангамжийн ажиллагааг зохион байгуулсан. Одоогийн байгаа тоног төхөөрөмжийн бүтэц нь шинээр зохион байгуулж, өргөтгөх боломжтой олон холболт бүхий Node шийдлээр тооцоолж хийсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын төв серверийн өрөөнд программ хангамжийн үндсэн сервер-1 ширхэг, өгөгдөл хадгалах сервер-1 ширхэг, нөөц тэжээл-1 багц тус тус ажиллаж байгаа ба “Зорчих эрхийг хязгаарлах ялын бүртгэл, хяналтын систем” нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас Газрын мэдээллийн сан, “Үндэсний дата төв” УТҮГ-ын “ХУР” төрийн мэдээлэл солилцооны системээс иргэний бүртгэлийн үндсэн мэдээллийг авч дотоод үйл ажиллагаандаа ашигладаг. Нэмэлт сайжруулалтын хүрээнд дээрх сүлжээний дэд бүтцийн тохиргоог шинээр зохион байгуулсан.

Dumpfile буюу мэдээллийн сангийн нөөц өгөгдлийг хуулбарлаж, сервер компьютерт зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем байршин ажиллах орчинг шинээр зохион байгуулж, 2228 цахим бугуйвчийн холболтыг үүсгэж, идэвхитэй 1342 цахим бугуйвчийг хяналтад оруулсан.

“Бодь-Электроникс” ХХК-д зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын системд гарч байгаа зарим алдааны талаарх мэдээлэл, алдааны шалтгаан нөхцөлийг тогтоох, программ хангамж /эх код/-ийг хүлээн авахад шаардлагатай засвар үйлчилгээг хийх, гэрээнд заагдсан баталгаат засварыг тухай бүр засварлах зэргээр хамтран ажиллаж байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд цахим хяналт тавих программ хангамжийг сайжруулах, хөгжүүлэлт хийх ажлын хүрээнд “Цахим хяналт, удирдлагын төвийн программ хангамж, серверийн хөгжүүлэлт, өргөтгөл хийх ажлын төсөл”, “Цахим хяналт, удирдлагын төв”-ийн дэд төвийг өргөтгөхөд шаардлагатай

180.2 сая төгрөгийн санхүүжилтийг Азийн хөгжлийн банкны 1.6 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжаас шийдвэрлүүлэх саналыг хүргүүлсэн.

БНХАУ-ын “Shenzhen Hexun Technology” Co.,LTD компаниас туршилтад ашиглагдах гар болон хөлийн цахим бугуйвч худалдан авч, туршилтын ажлыг зохион байгуулж, DDX-04, DDX-14 загварын 400 ширхэг цахим бугуйвчийг 50.000 ам доллароор худалдан авч, системд холбох ажлыг “СЭТТЭ” ХХК-тай “Ажил гүйцэтгүүлэх тухай” гэрээг байгуулж, ялын хэрэгжилтэд нэвтрүүлсэн.

## 2. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр:

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газартай хамтран ажиллах гэрээг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байгуулж, төлбөр төлөгчийн газрын мэдээллийг цахим хэлбэрээр солилцох ажлыг нэвтрүүлсэн.

Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр төлбөртэй эсэх тодорхойлолт, лавлагааг Төрийн худалдан авах ажиллагааны газрын Tender.gov.mn цахим хаягаас Голомт банкны цахим хуудас болон аппликейшнээр дамжуулан олгох ажлыг нэвтрүүлж, Голомт банкттай 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр 12/И-КҮБ/780 дугаар гэрээг шинэчлэн байгуулсан.

Төлбөр төлөгчийн дансны мэдээлэл авах, битүүмжлэх, суутгал хийх ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Тээвэр хөгжлийн банк, Хаан банкттай байгуулсан гэрээг шинэчилсэн бол Ариг банкттай 2022.08.30-ны өдрийн ШГА-16 дугаар хамтран ажиллах гэрээг тус тус байгуулсан.

Мөн шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөртэй эсэх талаарх лавлагааг цахим хэлбэрээр олгох ажлын хүрээнд Төрийн банкттай 2022.02.15-ны ШГА-14 дүгээр, Үндэсний хөрөнгө оруулалтын банкттай 2022.09.20-ны өдрийн ШГА-17 дугаар, Ариг банкттай 2022.09.28-ны өдрийн ШГА-18 дугаар хамтран ажиллах гэрээг тус тус шинэчлэн байгуулсан.

-Хил хамгаалах ерөнхий газартай хамтран 9129 гүйцэтгэх баримт бичигт холбогдох 2.0 их наяд төгрөгийн төлбөртэй 8189 төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж, 2350 төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг сэргээсэн.

## 3. Хорих ял эдлүүлэх чиглэлээр:

ШШГЕГ-ын харьяа анги, байгууллага хооронд үнэ төлбөргүй ярих тоон технологийн телефон утасны систем нэвтрүүлэх ажлын хүрээнд IP тоон технологийн 30 ширхэг аппаратыг 413, 417, 419, 423, 425, 445, 457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангиуд, Булган, Өвөрхангай, Увс аймаг дахь ШШГГ-д, “Хэрэмт цамхаг” УТҮГ, СМДӨЭАХХГ, Ханбогд, Багахангай, Налайх, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь ШШГХ буюу нийт 15 хорих анги, байгууллагад хуваарилан өгч, ашиглалтад оруулсан.

“ITZONE” ХХК-тай хамтран БНХАУ-ын “MEGVII” брендийн нүүр царай таних “Megeye-C3S-123” загварын телекамер, “Megserver-S1C-L3-L1” загварын өгөгдөл боловсруулах сервер, “Megbox-B1F-122” загварын дүрсний хайрцаг суурилуулж, программ хангамжийн систем хөгжүүлэлт /System installation and development/-ийг 421 дүгээр нээлттэй хорих ангийн байрлалд туршилтаар 60 хоригдлын нүүр царайг 14 хоногийн хугацаанд таниулах ажлыг зохион байгуулсан.

**Хоёр. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн орчинг шинэчлэн, хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд:**

1. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд бодлогын хэмжээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал,

2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгохоор болсонтой холбогдуулан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид мөнгөн урамшуулал олгох журам" Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 345 дугаар тогтоолоор батлагдсан. Ингэснээр 2023 онд **341** алба хаагчид **7.6** тэрбум төгрөг олгохоор 2023 оны төсвийн тухай хуульд туссан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 204 дүгээр тогтоолын хавсралтаар "Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэм"-ийг баталсан бөгөөд тус тогтоолын хавсралтын 17-д 435 дугаар хаалттай хорих ангийн байршлыг "Дархан уул аймаг, дархан сум" гэж заасныг өөрчлөн, хорих ангийн нутаг дэвсгэрийн байршлыг зөв тодорхойлж "435 дугаар хаалттай хорих анги, Сэлэнгэ аймаг, сайхан сум" гэж өөрчлүүлэх саналыг ХЗДХЯ-нд хүргүүлснээр Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 170 дугаар тогтоолоор "Дархан-Уул аймаг, Дархан сум" гэснийг "Сэлэнгэ аймаг, Сайхан сум" гэж өөрчлөлт орсон.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы хуралдаанаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн баталлаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага төрийн цэргийн байгуулалд хамрагдах эрх зүйн орчин бүрдсэнээр байгууллагын статус, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн эрх зүйн байдал зэрэг нь бусад төрийн цэргийн байгууллагатай нэгэн адил болж, Монгол Улсын хэмжээнд цэргийн албаны чиглэлээр батлагдсан гарсан хууль, дүрэм, журмыг мөрдөх үндсэн нөхцөл бүрдэж байгаа юм.

Түүнчлэн бусад нэмэлт өөрчлөлтөөр 2002-2018 онд энгийнээр ажиллаж байсан 103 шийдвэр гүйцэтгэгчийн ажилласан хугацааг цэргийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцох, зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс бус ялтанд гав зүүсэн үеэс эхлэн тоолох, баривчлах төв болон байранд ажиллаж буй алба хаагчдыг хорих байгууллагын алба хаагчтай адилтган үзэх нөхцөл бүрдлээ.

2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд аймаг сумын Засаг дарга тухайн нутаг дэвсгэр дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дарга, дэд даргыг орон сууцаар хангах арга хэмжээ авахаар тусгаж өгсөн.

2. Эрх зүйн актуудыг боловсронгуй болгох ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Зөрчлийн болон эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тухай хуулиудыг тус тус ШШГТХ-тай

харьцуулан судалж шинэчлэн найруулсан болон хасагдсан, зарчмын зөрүүтэй байдлын саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/71, А/72, А/73 дугаар тушаалуудаар Иргэний болон захиргааны хэргийн, Зөрчлийн болон эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тухай хуулийн төслүүдийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан.

Тус ажлын хэсгийн тушаалыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/93, А/94 дүгээр тушаалаар хуулийн төслүүдийг боловсруулах дэд ажлын хэсгүүд байгуулагдсан.

Ажлын хэсэг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухай”, “Эрүү, зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулийн төслийг боловсруулахдаа харьяа алба, газар, хэлтэс, салбар нэгжүүдээс нийт 3 удаа санал авах ажлыг зохион байгуулж, дэд ажлын хэсгийн хурлаар тус тус 7-10 удаа хэлэлцүүлсэн.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухай хууль”-ийн төслийг 5 бүлэг 57 зүйлтэйгээр, “Эрүү, зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн төслийг 7 хэсэг, 18 бүлэг, 169 зүйлтэйгээр тус тус боловсруулан, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу холбогдох судалгаа, тайлан, танилцуулгыг ХЗДХЯ-нд хүргүүлэхээр бэлтгэж байна.

- Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн 2006-2017 онд ШШГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан 65 эрх зүйн актын жагсаалтыг гаргаж, эдгээр хуулиудтай холбоотой 15 эрх зүйн актыг судлан, дүн шинжилгээ хийж холбогдох саналыг боловсруулсан.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй эрх зүйн актуудын хэрэгжилт, үр нөлөөнд дүн шинжилгээ хийх зорилгоор 8 журмыг шинэчлэх, 1 журмыг хүчингүй болгох, 14 журмын 142 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахаар дүн шинжилгээ хийсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар дараах журам, зааврыг тус тус шинэчлэн болон нэмэлт өөрчлөлт оруулан батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тухайлбал,

- 2022.01.19-ний өдрийн ХЗДХС, Улсын ерөнхий прокурорын хамтарсан А/10, А/03 дугаар тушаалаар “Хоригдлын ял эдлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх болон хорих ангийг солих тухай санал гаргах журам”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022.02.23-ны өдрийн А/37 дугаартай “Журам батлах тухай” тушаалаар “Шийдвэр гүйцэтгэгчийн хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх журам, загвар”, 2022.03.09-ний өдрийн А/49 дугаартай “Журам батлах тухай” тушаалаар “Хоригдол гэрээгээр ажиллуулахад мөрдөх журам”, 2022.10.24-ний өдрийн А/219 дугаартай “Журам, аргачлал батлах тухай” тушаалаар “ШШГБ-ын аюулгүй байдлын түвшин эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал, эрсдэлийн үнэлгээний хуудасны загвар, үнэлгээний асуумж”-ийг тус тус шинэчилж, 2022.02.08-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан “Нийслэл, аймгийн төвөөс бусад газарт байрлах хорих анги, хэсэгт алба хааж байгаа албан хаагчдын хоногийн хүнсээр хангах журам”-д нэмэлт, өөрчлөлт тус тус оруулсан.

**Гурав. Ногоон хөгжлийг дэмжиж “100 сая мод” хөдөлгөөн өрнүүлэх арга хэмжээний хүрээнд:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт бие бүрэлдэхүүн нэгдэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 100 сая мод тарих хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

2022 оны 05 дугаар сарын 14-ний өдөр “Бүх нийтийн мод тарих өдөр”-ийг тохиолдуулан Таширын аманд хотын бүсийн хорих анги, байгууллагын алба хаагчид нийт 2000 мод тарьж мод тарих хөтөлбөрийн үйл ажиллагааг эхлүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь ХААИС-ын Агроэкологийн сургуультай сургалт зохион байгуулах чиглэлээр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай үрсэлгээ нийлүүлэх болон бусад чиглэлээр хамтран ажиллах гэрээг тус тус байгуулсан.

ШШГЕГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/130 дугаар тушаалаар 100 сая мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн тушаалыг шинэчлэн баталж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 100 сая мод тарих хөтөлбөрийг ШШГЕГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/152 дугаар тушаалаар батлан, анги, байгууллагад хүргүүлсэн.

ХААИС-ийн “Агроэкологийн сургууль”-д ойжуулалтын чиглэлээр алба хаагчдыг 14 хоногийн сургалтад 51 алба хаагч хамруулж, гэрчилгээ олгосон бол хорих ял эдэлж 1170 хоригдлыг “Ойжуулалт”, “Агро-Ойжуулалт”, “Таримлын агротехнологи”, “Усалгаа”, “Бордоо”, “Ургамал хамгаалал”, “Арчилгаа”-ны чиглэлээр цахим сургалтад хамруулжээ.

2022 оны хаврын мод тарилтыг 2022 оны 05 дугаар сарын 14-21-ний өдрүүдэд зохион байгуулж, үрээр 404450, харандаа үрсэлгээгээр 310050, тарьц, суулгацаар 37041, **нийт 751541** ширхэг мод тарьсан.

2022 оны намрын мод тарилтыг 2022 оны 10 дугаар сарын 15-22-ны өдрүүдэд зохион байгуулж, тарьц, суулгацаар 20450, үрийн үрсэлгээгээр 23834, **нийт 75234** ширхэг мод тарьсан бөгөөд өнөөдрийн байдлаар байгууллагын хэмжээнд **826,775** ширхэг мод тариад байна.

100 сая мод тарих стратеги хөтөлбөрийн хүрээнд мод үржүүлгийн газрыг бий болгох зорилгоор 25 хорих анги, орон нутаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжид нийт 58,7 га газарт мод үржүүлгийн орчныг бий болгосон.

- Байгууллагын хэмжээнд 20 ширхэг хүлэмжийг байгуулан, агч мод, нарс, шинэс, хайлаас, шар хуайс, монос, голт бор зэрэг модны үрийн үрсэлгээг хийж, цаашид бойжуулах, ургуулах талаар зохих арга хэмжээг авч ажилласан.

### **2.3. Мэдлэг, ур чадвар, туршлагад суурилсан, улс төрөөс хараат бус, шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг сайжруулах талаар**

#### **2.3.1. Төрийн алба хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил, үр дүн, төрийн албан хаагчийг давтан сургах хэрэгцээг судлан хэрэгжүүлсэн ажил, үр дүн**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадвар, мэргэжлийн түвшинг дээшлүүлэх зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий

газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/218 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 2022 онд зохион байгуулах алба хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр”-ийг батлуулан шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжид хүргүүлж, сар бүр сургалтын тайлан мэдээг авч нэгтгэн, үүрэг чиглэл өгч, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

Сургалтын тайланг нэгтгэхэд харьяа анги, байгууллагууд алба хаагч бүрийг хөгжүүлэх, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хичээл сургалтыг батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө, цаг сэдвийн дагуу дараах 3 үндсэн хэлбэрээр зохион байгуулан ажиллалаа.

## НЭГ. АЛБА ХААГЧИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ

### 1.1 Албан хэрэг хөтлөлт, монгол хэлний зөв бичих дүрэм, албан бичгийн найруулга зүй, илтгэх ур чадвар эзэмшүүлэх сургалтын чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 299 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөлбөр”-ийн хүрээнд анги байгууллагууд дараах хичээл сургалтыг зохион явуулсан байна. Үүнд:

Хорих анги, байгууллага, салбар нэгжүүд нь төрийн болон төрийн бус байгууллага, их дээд сургуулийн багш, судлаачдыг урьж Үндэсний Монгол бичгийн “Цагаан толгой үсэг”, “Хос эгшиг”, “Гадаад үсэг”, “Үелэх ба цээжлэн тогтоох”, “Хуулан бичлэг хийх”, “Унших ба үсэглэх”, Монгол хэлний “Түгээмэл алдах магадлалтай үгийн зөв бичих дүрэм”, “Үндсэн ба туслах эгшиг”, “Урт ба хос эгшиг”, “Эгшиг зохицох ёс”, “Эр, эм, саармаг эгшиг”, “Заримдаг гийгүүлэгч эгшиггүй бичигдэх”, “Онцгой 4 гийгүүлэгч”, “Илтгэх ур чадварт суралцах”, “Сул үг, дагавар үгийг зөв бичих дүрэм”, “Үгийн сонголт ба өргөлт”, “Албан хэрэг хөтлөлтөд анхаарах асуудал”, “Зөв бичих дүрэм ба найруулга зүй”, “Эр, эм үгийн дагвар нөхцөл”, “Байгууллагын архивын үйл ажиллагаа”, зэрэг сэдвийн хүрээнд **15** цагийн лекц, **20** цагийн семинар, **15** цагийн бие даалт нийт **50** цагийн хичээл сургалтыг нийтлэг зохион байгуулжээ. Нийт **56** анги байгууллагын **2350** алба хаагч хамрагдсан байна.

Засгийн газрын “Монгол хэлний хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 07 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны хүрээнд байгууллагын алба хаагчдын монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор үндэсний монгол бичгийн түвшин тогтоох судалгааг төв аппаратын болон нийт анги байгууллага, салбар нэгжийн алба хаагчдаас авч нэгтгэхэд:

- эхлэн суралцагч /ямар ч мэдлэггүй/ -1001 буюу 34%
- анхан шатны мэдлэгтэй – 1420 буюу 48.2%
- дунд шатны буюу ахисан түвшний мэдлэгтэй – 523 буюу 17.8 % байна.

Дээрх судалгаанаас үзэхэд алба хаагчдад монгол бичгийн мэдлэг эзэмшүүлэх анхан шатны сургалтыг эрчимтэй зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байгаа нь харагдаж байна. Энэ ажлын хүрээнд анги байгууллага, салбар нэгж бүр дотооддоо мэргэжлийн багш нартай хамтран монгол бичгийн сургалт зохион байгуулан ажиллаж байна.

## 1.2 Гадаад хэлний мэдлэг, хэрэглээний чадварыг дээшүүлэх сургалтын чиглэлээр:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд гадаад хэлний сургалтын тогтолцоог байгууллагын чиг үүрэг, түүний онцлогтой уялдуулан бий болгох, алба хаагчдын мэргэжлийн англи хэлний ур чадварыг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн тул бодлогын хүрээнд сургалтын хөтөлбөрт энэ чиглэлээр оруулж өгсөн. Түүнчлэн “Гадаад хэл-мэдлэгийн түлхүүр” дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийг батлуулан, харьяа анги, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийт анги байгууллага, салбар нэгжийн 3001 алба хаагчийн англи хэлний мэдлэгийн түвшинг тодорхойлох судалгааг авч нэгтгэхэд эхлэн суралцагч 1981 буюу 66%, анхан шатны мэдлэгтэй 837 буюу 27.9%, дунд шатны мэдлэгтэй 179 буюу 6%, ахисан түвшний мэдлэгтэй 4 буюу 0.1% үзүүлэлттэй байсан.

Иймд хөтөлбөрийн I үе шатанд алба хаагчдад англи хэлний анхан шатны мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх үйл ажиллагааг эрчимтэй зохион байгуулахад түлхүү анхаарч ажилласан.

2020, 2021 онд цар тахлын улмаас сургалт ихэвчлэн цахим хэлбэрээр явагдсан учир үр дүн муутай байсан. 2022 оноос анги байгууллага, салбар нэгжүүд танхимын сургалтыг эрчимтэй зохион байгуулж, алба хаагчдыг идэвхжүүлээд байна.

ШШГЕГ-ын Захиргааны удирдлагын газраас байгууллагын алба хаагчдын англи хэлний мэдлэгийг сайжруулах зорилгоор албан хэрэгцээнд зориулсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн англи хэл” мэргэжлийн сурах бичиг, гарын авлагыг боловсруулан 625 ширхэг хэвлүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.

Гадаад хэлний мэдлэг, хэрэглээний чадварыг дээшлүүлэх сургалтын хүрээнд анги байгууллагууд дараах хичээл сургалтыг зохион явуулсан байна. Үүнд:

Гадаад хэлний мэдлэг, хэрэглээний чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөний дагуу өнгөрсөн, одоо, ирээдүй цаг, хавсарсан, нийлмэл болон тодотгол өгүүлбэр, харилцааны шинэ үг, унших, бичих, сонсгол, дуудлага засах, нийтлэг хэрэглэгддэг болон мэргэжлийн шинэ үг, дүрэм цээжлэх, бусад дүрмийн **10** цагийн лекц, унших, бичих, сонсгол, дуудлага засах **25** цагийн семинар, нийтлэг хэрэглэгддэг болон мэргэжилийн шинэ үг, дүрэм цээжлэх **10** цагийн бие даалт нийт **45** цагийн хичээл сургалтыг нийтлэг зохион байгуулжээ. Нийт **56** анги байгууллагын **2350** алба хаагч хамрагдсан байна.

Дээрх сургалтын чиглэл болон хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах эхний түвшинд анги байгууллага бүр дотооддоо гадаад хэлний сургалтын төв, их, дээд сургууль болон Ерөнхий боловсролын сургуулийн багш нартай хамтран ажиллах гэрээ байгуулан, алба хаагчдад англи хэлний анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулан биелэлтийг ханган ажилласан байна.

Түүнчлэн анги, нэгж бүр англи хэлний танин мэдэхүйн булан, самбар ажиллуулж, шинэ үг, өгүүлбэр нүдлүүлэх, бие даалтаар даалгавар өгч эргэн шалгах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж ажиллажээ.

Англи хэлний мэдлэг нь төрийн алба хаагчдад тавигдах шалгуур үзүүлэлт, заавал эзэмших шаардлагатай ур чадварын нэг болсон гэдгийг ухамсарлуулан, алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөн дэх мэдлэг чадвараа дээшлүүлэхэд хэрэгжүүлэх нэг гол үзүүлэлт болгон тусгайлан тусгаж, түвшинг тогтоон үнэлж дүгнэх ажиллагааг нэвтрүүлж эхэлсэн нь алба хаагчид бие даан суралцах, өөрийгөө хөгжүүлэх түлхэц болж байна.

Цаашид сургалтад хамрагдсан алба хаагчид харьяа анги, нэгжид англи хэлний сургалт зохион байгуулах, байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бичгийн орчуулга хийх, олон улсын зочид төлөөлөгчидтэй харилцах, бусад улс орны ижил чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, гадаад улсад суралцах чадамжтай сургагч багш, англи хэлний мэдлэгтэй боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх зорилготой ажиллаж байна. Түүнчлэн алба хаагчдад өөрийн хүсэлтээр цалинтай чөлөө авч, англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх боломжийг олгохоор төлөвлөсөн.

### **1.3 Бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтын чиглэлээр:**

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн 2022 оны 05 дугаар захирамжаар өгсөн чиглэлийн дагуу 2022-2027 онд хэрэгжүүлэх “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, алба хаагчдын эрүүл мэнд, зөв зохистой амьдралын хэв маяг хэвшүүлэх, албаны болон хувийн аюулгүй байдлын хангах, эрсдэл, хүндрэлтэй нөхцөлийг даван туулах чадвар олгох зорилго бүхий бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтын хүрээнд анги, байгууллагууд дараах хичээл сургалтыг зохион явуулсан байна. Үүнд:

Бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтын хөтөлбөрт тусгагдсан хүч, хурд, тэсвэр, авхаалж самбаа, уян хатан, тактик ажиллагааны болон албаны бэлтгэлийн онолийн ойлголт зэрэг сэдвийн хүрээнд **6** цагийн лекц, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/505 дугаар тушаалаар баталсан “Цэргийн алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилтийн норматив”-д заасны дагуу **40** цагийн семинар, **14** цагийн бие даалт нийт **60** цагийн хичээл сургалтыг нийтлэг зохион байгуулжээ. Нийт **56** анги байгууллагын **2350** алба хаагч хамрагдсан байна.

Нийт алба, газар, хорих анги, байгууллага, хэлтэс, салбар нэгжүүд алба хаагчийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бие бялдрын бэлтгэлжилтийг хангах үйл ажиллагааг тусгайлан заалт болгон тусгаж оруулжээ.

- Хурдны дасгал;
- Хүчний дасгал;
- Тэсвэр хатуужлын дасгал;
- Уян хатны дасгал;
- Авхаалж самбаа гэсэн хэлбэрээр хичээл сургалт, дадлага сургуулилтыг гүйцэтгэсэн байна.

ШШГБ-ын алба хаагчийн цэргийн бэлтгэлийн шалгуурыг шалгаж, үнэлэхдээ ЗХЖШ-ын даргын 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/505 дугаар тушаалаар баталсан “Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт”-ыг баримтлан нас, хүйсийн ангилалаар ангилан, цаг үеийн нөхцөл байдал, үйл ажиллагааны онцлог, газар зүйн байршлын нөхцөл байдлаас хамааран алба, газар, хэлтэс, хорих анги,

байгууллага, салбар нэгжийн даргын тушаалаар төлөвлөгөө гарган дотооддоо бие бялдрын бэлтгэлжилтийн шалгуур үзүүлэлтийн үзлэг, шалгалтыг зохион байгуулжээ.

Мөн алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг тогтоох, шалгуур үзүүлэлтийг шалгаж, дүгнэх үед гэнэтийн эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлж эмнэлгийн баг, эмч, сувилагч ажиллуулжээ.

Алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн шалгалтын дасгалд хурд, хүч, тэсвэр, уян хатны дасгалаас тус бүр 1, авхаалж самбаа, тусгай бэлтгэлийн дасгалаас 1 дасгал тус тус сонгож, нийт 4-5 дасгалаар шалгаж дүгнэн ажилласан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих анги, байгууллага, хэлтэс, салбар нэгж нь алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилтийг заасан багц цагийн дагуу улирал бүр зохион байгуулсан.

Алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилт, норматив хангах шалгалтад **56** алба газар, хорих анги, байгууллага, салбар нэгжийн хамрагдвал зохих **2931** алба хаагчаас **2369** цэргийн алба хаагч хамрагдаж **A-455, B-898, C-728, D-283, F-28** үнэлэгээтэй дүгнэгдсэн.

Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт, нормативыг хангасан эсэхийг нэгтгэн дүгнэхэд хангалттай **2263** хангалтгүй **131** алба хаагч байна.

Хангалтгүй **F** үнэлгээ авсан алба хаагч нарт хорих анги байгууллагын удирдлагууд 1-3 сарын хугацаатай анхааруулга, зөвлөмж, үүрэг өгч дасгал сургуулилтыг эрчимжүүлэх арга хэмжээг эхлүүлээд байна.

#### **1.4 Цэргийн албаны нийтлэг дүрэм, цэргийн хэргийн мэдлэг олгох сургалтын хүрээнд:**

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дүрэмч, жагсаалч байдал, дүрэмт хувцасны зөв хэрэглээ, хувь хүний соёлыг дээшлүүлж, төрийн тусгай алба хаагчдын нийгэмд эзлэх байр суурь, манлайллыг нэмэгдүүлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”-ийг мөрдүүлэх, цэргийн дүрэмт хувцасны үзэмжтэй, соёлтой хэрэглээг хэвшүүлэх “Цэрэгжилт, жагсаалч байдлыг сайжруулах, жагсаалын бэлтгэл сургуулилт, цэргийн дүрэмт хувцасны үзлэг, сургалт, хяналт”-ыг эрчимжүүлэн, сургалт, сурталчилгааг тогтмолжуулах зорилго бүхий сургалтын хүрээнд анги байгууллагууд дараах хичээл сургалтыг зохион явуулсан байна. Үүнд:

Анги байгууллагууд сургалтын төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн анги байгууллага, нэгтгэлтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, мэргэжлийн арга зүйчээр “Цэргийн нийтлэг дүрэм”, “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”, “Цэргийн дүрэмт хувцасны загвар, стандарт”, “Цэргийн алба хаагчдын харилцаа” зэрэг сэдвийн хүрээнд **10** цагийн лекц, **20** цагийн семинар, **20** цагийн бие даалт нийт **50** цагийн хичээл сургалтыг **56** анги байгууллагын **2350** алба хаагч хамрагдсан байна.

“Цэрэгжилт, жагсаалч байдлыг сайжруулах, жагсаалын бэлтгэл, сургуулилт, цэргийн дүрэмт хувцасны үзлэг, сургалт, хяналт”-ыг эрчимжүүлэх зорилгоор дараах ажил, арга хэмжээг нийтлэг байдлаар зохион байгуулсан.

### **1.5 Галт зэвсэг, тусгай хэрэгслэлийн дадлага сургалтын хүрээнд:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын манлайллыг нэмэгдүүлэх, галт зэвсэг, тусгай хэрэгслийн тухай ойлголт, төрөл хэлбэр, галт зэвсгийн бүтэц, зохион байгуулалт, буудлагын төрөл, буудлага үйлдэх үеийн аюулгүй ажиллагаа, буудлагын арга техник, ур чадварыг эзэмшүүлэх зорилго бүхий сургалтын хүрээнд анги байгууллагууд дараах хичээл сургалтыг зохион явуулсан байна. Үүнд:

Анги байгууллагууд сургалтын төлөвлөгөөний дагуу хорих анги, байгууллага, салбар нэгжүүд “АК, АКМ, ПМ бууны хагас, бүтэн задаргаа”, “Галт зэвсгийн аюулгүй ажиллагаанд анхаарах асуудал”, “ШШГБ-ын ажилтан галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх мэдээлэх журам”, “ШШГБ-ын алба хаагчийн хэрэглэх техник хэрэгсэл галт зэвсэг сумыг бүртгэх олгох буцаан авах хадгалах журам”, “ШШГБ-ын алба хаагч биеийн хүч тусгай хэрэгсэл галт зэвсэг хэрэглэх журам” зэрэг сэдвийн хүрээнд **10** цагийн лекц, **20** цагийн семинар, **10** цагийн бие даалт нийт **40** цагийн хичээл сургалтыг нийтлэг зохион байгуулжээ. Нийт **56** анги байгууллагын **2350** алба хаагч хамрагдсан байна.

Сургалтын явцын тайлан мэдээ нэгтгэхэд “.....Анх удаа галт зэвсэг харж байгаа алба хаагч байсан.....” сургалтыг дуусах үед хууль, эрх зүйн орчинг нь судалсан, хагас задаргаа хийдэг болсон байна.

### **1.6 Сургалтын тоглолт, команд штабын сургалт, дадлага сургалтын хүрээнд:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад аюулгүй байдлын сургалт, дадлагыг алба хаагчдыг тодорхой эрсдэлт нөхцөл байдал үүссэн үед шаардлагатай шийдвэрийг оновчтой шуурхай гаргах, болзошгүй үеийн нэгдсэн зохион байгуулалтад шилжих, үүсч болох аюул заналаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадвар эзэмшүүлэх зорилго бүхий сургалтын тоглолт, команд штабын сургуулилтын хүрээнд анги байгууллагууд дараах хичээл сургалтыг зохион явуулсан байна. Үүнд:

Нийт хорих анги, байгууллага, салбар нэгжүүд нь сургалтын төлөвлөгөөний дагуу “Хоригдол, хоригдогч оргох, үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, өсгөлөн суулт зарлах”, “Гал түймэр, гамшиг осол, газар хөдлөлт, халдварт өвчлөл” зэрэг сэдвийн хүрээнд **10** цагийн лекц, **10** цагийн семинар, **10** цагийн бие даалт нийт **30** цагийн хичээл сургалтыг **12** анги байгууллагын **960** алба хаагч хамрагдсан байна.

Алба хаагчийг чадавхжуулах дээрх чиглэлийн сургалтууд нь тогтмол шинжтэй зохион байгуулагдсан ба харьяа салбар, нэгжийн дарга нар өөрсдийн эрх хэмжээний хүрээнд тушаал гарган хугацаа, байршил, хэлбэрийг тусган сургалтыг үр дүнтэй зохион байгуулсан байна.

“Албан хэрэг хөтлөлт, монгол хэлний зөв бичих дүрэм, албан бичгийн найруулга зүй, илтгэх ур чадвар эзэмшүүлэх сургалт” **88%**, “Гадаад хэлний мэдлэг,

хэрэглээний чадварыг дээшүүлэх сургалт” **65%**, “Бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалт” **86%**, “Цэргийн албаны нийтлэг дүрэм, цэргийн хэргийн мэдлэг олгох сургалт” **92%**, “Галт зэвсэг, тусгай хэрэгслэлийн дадлага сургалт” **90%**, “Сургалтын тоглолт, команд штабын сургалт, дадлага сургалт” **60%** биелэлттэй тус тус зохион байгуулагдаж, хөтөлбөрийн **чанар-92,8%, амжилт-86,6%**-тай хорих анги байгууллага ажлын ачаалал, онцлогийг харгалзан бүрэн хэрэгжүүлж зохион байгуулжээ.

#### ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ ЦАХИМ СУРГАЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдыг ажлын байран дээр нь мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг сайжруулах зорилгоор дараах агуулгын хүрээнд цахим сургалт зохион байгуулсан.

Анги байгууллага, салбар нэгжийн цахим сургалтад хамрагдсан алба хаагчдын тоон мэдээллийг тухай бүр авч нэгтгэн, бүртгэл хөтлөн ажилласан.

Нийт **14** удаагийн **28** цагийн хичээл сургалтад анги, байгууллагын **24.450** /давхардсан тоогоор/ алба хаагч цахимаар, **628** /давхардсан тоогоор/ алба хаагч танхимын хэлбэрээр тус тус хамрагдсан.

Хичээл сургалтыг цахим хэлбэрээр явуулахад цаг хугацаа, төсөв санхүү, бие даан судлах, иргэдэд хүндрэл, чирэгдэл учрахгүй байх ач тустай боловч алба хаагчдын хичээлийн ерөнхий ойлголт хүлээн авч буй байдал харилцан адилгүй байна гэсэн дүгнэлттэй байна.

#### ГУРАВ. ТӨРӨЛ, МЭРГЭЖЛИЙН АЛБА ХААГЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ

Төрөл, мэргэжлийн алба хаагчийг мэргэшүүлэх сургалтыг нэгж, салбарын мэргэжлийн албан тушаал тус бүрээр харьяалах алба, газраас ирүүлсэн саналыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/218 дугаар тушаалаар батлагдсан хөтөлбөрт тусгагдсан хуваарийн дагуу дараах төрөл мэргэжлийн алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан.

Мэргэшүүлэх сургалт нь дараах үндсэн хэлбэртэй зохион байгуулагдсан.  
Үүнд:

- Төвлөрсөн;
- Бүсчилсэн;
- Зайны буюу цахим;
- Ажлын байран дээрх сургалт зэрэг болно.

Алба хаагчийг мэргэшүүлэх сургалт нь агуулга, сэдэв, хэлбэрийн хувьд давхцахгүйгээр мэргэжлийн удирдлагын багаас боловсруулсан чухал шаардлагатай сэдвийг багтаасан хөтөлбөрийн хүрээнд дараах хичээл сургалтыг зохион явуулсан байна.

#### 2.3.2. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг сайжруулах талаар

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, **Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын дагуу “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх 2021-2024 оны дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө”-г боловсруулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/43 дугаар тушаалаар баталж, анги байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.**

Тус хөтөлбөрт **1** зорилго, **6** зорилт, **51** арга хэмжээг 2022-2024 он хүртэл **2** үе шаттай хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 2022 оны жилийн эцсийн байдлаар багцлан дурдвал,

**1 дүгээр зорилт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч, ахмад настны нийгмийн хамгааллыг бэхжүүлэхэд чиглэгдсэн эрх зүйн баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөлтийг төрийн бодлого, шийдвэрт нийцүүлэн боловсронгуй болгох;**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа 55 анги, байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд алба хаагчийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх арга хэмжээг тусган өгч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ШШГЕГ-ын даргаар батлуулан анги, байгууллагад хүргүүлж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцож байна.

2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгохоор болсонтой холбогдуулан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын төслийг боловсруулан Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 345 дугаар тогтоолоор батлагдсан.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы хуралдаанаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн баталсан. Ингэснээр,

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага төрийн цэргийн байгуулалд хамрагдаж, 2002-2018 онд шийдвэр гүйцэтгэгчээр ажиллаж байсан **103** шийдвэр гүйцэтгэгчийн энгийнээр ажилласан хугацааг цэргийн албанд тооцуулж;

- Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс бус ялтанд гав зүүсэн үеэс эхлэн тоолж;

- Баривчлах төв болон байранд ажиллаж буй алба хаагчдыг хорих байгууллагын алба хаагчтай адилтган үзэх нөхцөл бүрдсэн.

2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд аймаг сумын Засаг дарга тухайн нутаг дэвсгэр дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дарга, дэд даргыг орон сууцаар хангах арга хэмжээ авахаар тусгаж өгсөн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/244 дүгээр тушаалаар 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хүүхэд асрах чөлөөтэй байгаа алба хаагчдын цэргийн цолны цалинг олгохоор шийдвэрлэснээр хүүхэд асрах чөлөөтэй байгаа алба хаагчдын нийгмийн асуудал шийдвэрлэгдэж, амьдрал ахуйд нь дэмжлэг болохуйц нөхцөлийг бүрдүүлэн, тэдний тогтвор суурьшилтай ажиллах урам зоригийг нэмэгдүүллээ.

**2 дугаар зорилт: Байгууллагын хэмжээнд албан хаагчийн ажлын байрны орчин нөхцөл, албаны үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт, шаардлагад нийцүүлэх;**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд санхүүжүүлэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэрэгцээнд компьютер, техник хэрэгсэл нийлүүлэх ХЗДХЯ/202212008 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 2022.03.23-ны өдөр гэрээ байгуулж, нийт 310 ширхэг суурин компьютер, 100 ширхэг олон үйлдэлт хэвлэгч, 4 ширхэг сервер компьютер зэрэг нийт 807.6 сая төгрөгийн компьютер техник хэрэгсэл худалдан авч хангалт хийсэн.

Тайлант хугацаанд 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн гадна болон дотор тал, 407, 413, 415, 437, 445 дугаар нээлттэй, хаалттай хорих ангиуд албан конторыг засварлаж алба хаагчдын ая тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Цэргийн алба хаагчдад 18 нэр төрлийн **1,320.8** сая төгрөгийн цэргийн дүрэмт хувцас, хэрэглэл олгожээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 30 асуулга бүхий ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаанд 1650 орчим алба хаагч хамрагдлаа. Тус судалгаанд хамрагдсан нийт алба хаагчдын 70 хувь нь сэтгэл ханамжтай, 20 хувь нь дунд зэрэг, 10 хувь нь ханамжгүй гэсэн хариулт ирүүлжээ.

**3 дугаар зорилт: Албан хаагчдын албан тушаалын чиг, үүргээ хэвийн хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүйн болон нийгэм, эдийн засгийн баталгааг бүрэн ханган, тэдний тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх;**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор 2022 онд нийт 159 орон тоо нэмэгдсэнээс ШШГЕГ-ын даргын 2022.02.09-ний өдрийн А/23, А/24, А/25, А/26, А/27, А/28, А/29, А/30 дугаар тушаалуудаар Хорих ял эдлүүлэх албанд 61, Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газарт 8, Шийдвэр гүйцэтгэх албанд 14, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд 40, "Соёмбо" чуулгад 36 орон тоо тус тус хуваарилсан.

ШШГЕГ-ын даргын 2020 оны А/96 дугаар тушаалаар батлагдсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-д заасны дагуу системийн хэмжээнд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд **327,9** сая төгрөг,

тэтгэврийн зардалд **3,631,5** сая төгрөг, бичиг хэргийн зардалд **24.2** сая төгрөг тус тус зарцуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/77 дугаар тушаалын дагуу “Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал” буюу гадаадад суралцагчдын зардлаас гадаадын их, дээд сургуулийн бакалавр, адъюнктур, докторантурт ОХУ-ын их сургуульд суралцаж буй 22 алба хаагчид үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг, цолны мөнгө, унааны зардалд **209.2 сая** төгрөг олгосон.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 11-р хороо, Зайсангийн аманд 840 айлын 10 блок орон сууц, ногоон байгууламж, ил ба далд авто зогсоол, үйлчилгээний төв бүхий “Хуулийн байгууллагын ажилтан, алба хаагчдын орон сууцны цогцолбор”-ын төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд баригдаж буй 118 айлын орон сууцны 107, 108 дугаар байрны барилга угсралтын ажил 89.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Уг барилгуудыг 2023 оны 2 дугаар улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.

**4 дүгээр зорилт:** Албан хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээг тэдний авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх шаардлагатай уялдуулан хэрэгжүүлэх;

Тус зорилтын хүрээнд нийт салбар нэгжүүдийн алба хаагчдын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор бялдаржуулах төв, усан бассейн, спиннинг клубуудад хөнгөлттэй үнээр хамруулж, орон нутаг дахь спорт заалуудтай гэрээ байгуулан, спортын уралдаан тэмцээн зохион байгуулсан байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон Хорих ял эдлүүлэх албаны алба хаагчид 7 хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагт спорт зааланд сагс, гар бөмбөг тоглож байна.

2022 оны 01 сараас эхлэн 7 хоног бүрийн 2, 4, 6 дахь өдрүүдэд тус байгууллагын алба хаагчдын 9-15 насны 16 хүүхдэд Волейболын дугуйлан тогтмол хичээллүүлж байна.

419 дүгээр нээлттэй хорих анги, 441 дүгээр нээлттэй хорих анги, Баривчлах байр, Дорнод, Завхан аймаг дахь ШШГГ нь бялдаржуулах өрөө тохижуулсан бол Завхан аймаг дахь ШШГГ, Ховд аймаг дахь ШШГГ-457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь алба хаагчиддаа зориулж “Хүүхэд харах өрөө”-г шинээр бий болгожээ.

Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх, биеийн тамир, спортын үйл ажиллагаа явуулах орчин нөхцөл бүрдүүлэх зорилгоор 439 дүгээр хаалттай ангийн дэргэд спорт заалыг 2021 онд эхлүүлсэн бөгөөд Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар /Х.7.1.1/ 490,0 сая төгрөг батлагдаж барилгын ажил үргэлжилж байгаа ба одоогийн байдлаар барилгын тайлант оны гүйцэтгэл 85,3 хувь нийт гүйцэтгэл 59,3 хувьтай байна.

401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг Хан-Уул дүүргийн “Royal Smile dental clinic” эмнэлэгтэй хамтран алба хаагчдын хүүхдүүдийг эрүү нүүрний үзлэгт хамруулах, 409 дүгээр хаалттай хорих анги “Тандаа баярлалаа” өдөрлөг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эртэч Монгол” үндэсний хөдөлгөөний

хүрээнд 413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги “Эрүүл эртэч алба хаагч” аян, 441 дүгээр нээлттэй хорих анги “Бид эртэч, эрүүл чийрэг цэргийн алба хаагчид” 1 сарын аян, 415 дугаар нээлттэй, хаалттай хорих анги “Бүх хайраа хүүхдүүддээ” арга хэмжээ, 417 дугаар нээлттэй хорих анги “Хайраар дүүрэн гэр бүл өдөрлөг”, 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг “Эрүүл бие, зөв амьдрал” 2 сарын аян, 425 дугаар нээлттэй хорих анги “Эх үрсийн инээмсэглэл-Бидний аз жаргал” арга хэмжээ, 427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги “Гэр бүлийн өдөрлөг”, 435 дугаар хаалттай хорих анги “Идэхтэй хөдөлгөөн-Эрүүл бие-Дугуйн аян”, 439 дүгээр хаалттай хорих анги “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл мэнд”, 445 дугаар нээлттэй, хаалттай хорих анги “Хүүхэд бидний ирээдүй” арга хэмжээ, Баривчлах төв “Амьдрал бэлэглээ” сайн үйлсийн аян, Говь-Алтай аймаг дахь ШШГГ “АХА” танин мэдэхүйн нэвтрүүлэг, Завхан аймаг дахь ШШГГ “Гэр бүл-хамтын ажиллагаа” өдөрлөг, Үйлдвэр аж ахуй, барилгын хэлтэс “Тамхигүй орчин бүтээцгээе” аян, Баривчлах байр алба хаагчдын хүүхдүүдийн дунд Эх үрсийн баярыг тохиолдуулан “Ногоон дэлхий бидний гэр, Миний аав, ээж өргөсөн тангарагтаа үнэнч” гар зургийн уралдаан, Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран алба хаагчдын хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах зэрэг олон нийтийн арга хэмжээг зохион байгуулжээ.

**5 дугаар зорилт:** Албан хаагч, ахмад настнуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах бодлогын үйл ажиллагааг тогтмолжуулан, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд нийт **1756** ахмад настан бүртгэлтэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа анги, байгууллагууд алба хаагчдыг орон нутгийн эрүүл мэндийн төвүүдэд үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулж байна. Тухайлбал;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа эмнэлэг, эмнэлгийн хэсэг нь Халдвар судлалын үндэсний төв, 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг, 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг, сумын нэгдсэн эмнэлэгтэй хамтран дотор, мэдрэл, чих, хамар, хоолой, шүд, зүрх судас, цээжний рентген, хэвлийн ЭХО, зүрхний цахилгаан бичлэг зэрэг үзлэг, шинжилгээ оношилгоонд нийт **390** алба хаагчдыг хамруулсан.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх вакцины IV тунд 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн вакцинжуулалтын баг, аймаг, сумын нэгдсэн эмнэлэгтэй хамтран нийт **374** алба хаагчийг хамруулсан байна

“Дархлаа дэмжих багц”, “Гар угаах”, “Хандлагаа өөрчилж, дархлаагаа дэмжицгээе”, “Хогоо хогийн саванд хийцгээе”, “Өглөөний цай, өнөөдрийн дархлаа”, “Бид таны төлөө, та бас хичээгээрэй, хамтдаа дархлаагаа дэмжицгээе”, “Ковидын дараах нөхөн сэргээх эмчилгээ”, “Таны талархал бусдад дархлаажуулалт” зэрэг аяныг тус тус зохион байгуулж **490** алба хаагчийг хамруулсан.

Жилийн эцсийн байдлаар “Урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг оношлогоо, шинжилгээ”-нд нийт 27 хорих анги, байгууллагын **1124** алба хаагч хамрагдсан байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар ШШГБ-ын "Ахмадын хороо"-ноос ахмад настнуудын дунд нийтийн биеийн тамир, спортыг дэлгэрүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор шатар, ширээний теннис, дартс, бильярд гэсэн спортын дөрвөн төрөлт тэмцээнийг зохион байгууллаа.

Тус тэмцээнд 21 анги, байгууллагын 170 гаруй ахмад тамирчин өрсөлдсөнөөс төрөл тус бүрээр эхний 1, 2, 3 дугаар байрыг шалгаруулж, диплом мөнгөн урамшуулал олгосон. Түүнчлэн багийн дүнгээр тэргүүлсэн анги, салбар, нэгжид шилжин явах цомыг гардууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 181 алба хаагч, 492 ахмад ажилтан, нийт 673 алба хаагчийг төрийн дээд одон медалиар шагнасан. Үүнд: "Гавьяат хуульч" 2 ахмад ажилтан, "Гавьяат тамирчин" 1 алба хаагч, "Цэргийн гавьяаны улаан тугийн одон"-оор 2 алба хаагч, "Цэргийн гавьяаны одон"-оор 11 алба хаагч, 1 ахмад ажилтан, "Цэргийн хүндэт медаль"-иар 70 алба хаагч, "Ардын хувьсгалын 100 жилийн ойн медаль"-иар 97 алба хаагч, 489 ахмад ажилтан байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар нийт 468 алба хаагчийг шагнасан. Үүнд: "Хууль зүйн албаны тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр 28 алба хаагч, 2 ахмад ажилтан, "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр 152 алба хаагч, "Хүндэт жуух бичиг"-ээр 286 алба хаагч шагнагдсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шагналаар 1301 алба хаагч, 113 ахмад ажилтныг шагнасан.

**6 дугаар зорилт: Ахмад настанд үзүүлэх үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх, дэмжлэг, туслалцааг тогтмол үзүүлэх:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргаар ажиллаж байсан бэлтгэл хурандаа Г.Дэндэв, бэлтгэл хурандаа Ж.Чойндон нарт Монгол Улсын гавьяат цол, ахмад настан Д.Мягмарт Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол олгосон.

ШШГЕГ-ын ахмадын санд 5.900.000, 419 дүгээр нээлттэй хорих анги ахмадын санд 2.500.000, 415 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн ахмадын санд 1000.000, 421 дүгээр нээлттэй хорих анги 2.100.000, Мэргэжлийн сургалт-үйлдвэрэлийн төвийн ахмадын санд 420.000 төгрөг тус тус байршуулжээ.

Монголын Уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан ШШГЕГ 89 ахмад настанд 8.900.000, 401 дүгээр хаалттай хорих анги 107 ахмад настанд 5.112.600, 405 дугаар хаалттай хорих анги 129 ахмад настанд 10.836.000, 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги 2 ахмад настанд 300 шуудай мод, 100 шуудай түлш мөн 65 ахмад настанд 9.100.000, 409 дүгээр хаалттай хорих анги 52 ахмад настанд 4.368.000, 415 дугаар нээлттэй, хаалттай хорих анги 73 ахмад настанд 5.964.000, 419 дүгээр нээлттэй хорих анги 1 ахмад настны эмчилгээний зардалд 500.000, 421 дүгээр нээлттэй хорих анги 63 ахмад настанд 7.999.740, 425 дугаар нээлттэй хорих анги 1 ахмад настанд 300.000, 427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги 76 ахмад настанд 6.384.000, 437 дугаар нээлттэй хорих анги 17 ахмад настанд 1.344.000, 445 дугаар нээлттэй, хаалттай хорих анги 36 ахмад настанд 1.800.000, Цагдан хорих 461 дүгээр хорих анги 130 ахмад настанд 10.920.000, Архангай аймаг дахь ШШГГ 11 ахмад настанд 693.000, Булган аймаг дахь ШШГГ 6 ахмад настан 600.000, Дорнод аймаг дахь ШШГГ 10 ахмад настанд 460.000, Дундговь аймаг дахь ШШГГ 13 ахмад настанд 650.000, Завхан аймаг дахь ШШГГ 6 ахмад настанд 420.000,

Өмнөговь аймаг дахь ШШГГ 5 ахмад настанд 200.000, 2 ахмад настанд 1 тн нүүрс, Төв аймаг дахь ШШГГ 16 ахмад настанд 640.000, Увс аймаг дахь ШШГГ 14 ахмад настанд 12.000.000, Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв 5 ахмад настанд 420.000 нийт **929** ахмад настанд **89.028.340** төгрөгийн тусламж үзүүлжээ.

“Хэрэмт цамхаг” УТҮГ нь 2 өндөр настанд тус бүр 20м<sup>3</sup> блок өгсөн бол “Төр хур” амралт сувиллын газар 2022 оны эхний хагас жилийн байдлаар хөдөлмөр халамжийн эрхийн бичгээр 173 ахмад настан, хүлээн авч, үйлчилгээ үзүүлсэн байна.

ШШГЕГ-ын ахмадуудад 42 шуудай хүнсний ногоо, 10 хонины мах, 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги 20 ахмад настанд 300 шуудай мод, 100 шуудай сайжруулсан түлш, Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага 6 ахмад настанд 6 тн нүүрс, 413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги “Аав, ээжүүдийнхээ алдрыг дуурсья” өдөрлөг, 419 дүгээр нээлттэй хорих анги 2 ахмад настанд 3м<sup>3</sup> түлээний нүүрс, Говьсүмбэр аймаг дахь 425 дугаар нээлттэй хорих анги 63 ахмад настанг хөнгөлттэй үнээр амралтанд амруулах, 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 5 ахмад настанг “Төр хур” АСГ-т үнэ төлбөргүй амруулах, 439 дүгээр хаалттай хорих анги 1 ахмад настны хашаа байшинг засварлах, Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих анги эмчилгээний зардал болон ар гэрт нь гачигдал гарсан 78 ахмад настанд 5.900.000 төгрөгийн тусламж, Говь-Алтай аймаг дахь ШШГГ “Залуу хойч үедээ захиж үлдэх сургамж” арга хэмжээ, Дундговь аймаг дахь ШШГГ 8 ахмад настанд 8 тн нүүрс, Өмнөговь аймаг дахь ШШГГ 2 ахмад настанд 1 тн нүүрс олгох, Төв аймаг дахь ШШГГ 2 ахмад настанг хөнгөлттэй үнээр амралт сувиллын газар амруулах, Увс аймаг дахь ШШГГ 1 ахмад настанд иж бүрэн гэрийн тавилга олгох зэргээр олон нийтийн арга хэмжээ болон тусламж дэмжлэг үзүүлсэн байна.

### **Гурав: Бусад ажил:**

3.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу иргэд, олон нийт Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй тодорхойлолтыг төрийн үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia системээр дамжуулан авахад программ хангамж, сүлжээний байнгын тасралтгүй үйл ажиллагааг ханган Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй тодорхойлолтыг төрийн үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia системээр дамжуулан авахад программ хангамж, сүлжээний байнгын тасралтгүй үйл ажиллагааг ханган 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 73644 иргэн, 666 иргэн /англи/, ТҮЦ машинаар 27736 иргэн лавлагаа авсан.

Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй тодорхойлолтыг төрийн үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia системээр дамжуулан авахад программ хангамж, сүлжээний байнгын тасралтгүй үйл ажиллагааг ханган 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 3035 аж ахуйн нэгж лавлагаа авсан.

Хорих, анги байгууллагаас 2022 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар хорих ял эдлээд суллагдсан 371 иргэдийн мэдээллийн санг Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд шилжүүлж, Тус лавлагаа, үйлчилгээг Төрийн үйлчилгээний цахим машин /ТҮЦ машин/, Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/-аас 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 91 иргэн үйлчилгээ авсан байна.

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын мэдээллийн сүлжээний нэгдсэн гарц дээр цахим халдлагын эсрэг галт ханын төхөөрөмжийг суурилуулахаар СҮХОГ-т холбогдох тоног төхөөрөмжийн үзүүлэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр хүргүүлсэн. Худалдан авах ажиллагааны хуулийн дагуу нийлүүлэгчээр шалгарсан АйТиЗон ХХК-ний Fortinet төхөөрөмжийн албан ёсны лицензийг авах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр [security@fortinet.com](mailto:security@fortinet.com) цахим шууданд хандсан. Нийлүүлэгч талаас тус төхөөрөмжийг 2022 оны 07 дугаар сарын 31-ний өдөр нийлүүлэхээр 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 02-1051 дугаар албан бичгээр хүсэлтийг ирүүлсэн.

ХЗДХС-ын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн шуурхай хуралдаанаас өгсөн "Цахим хөгжлийн багц хуулийн хэрэгжилтэд анхаарч, өөрийн байгууллагад хамааран хэрэгжүүлэх асуудлаар дотоодоо журам, төлөвлөгөөг боловсруулж, мөрдөн ажиллах" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр ШШГЕГ-ын даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 11-ний хугацаанд Цагдан хорих төвөөс хоригдогсдыг цахим хэлбэрээр шүүх үйл ажиллагаанд оруулах, ачааллыг бууруулж түргэн шуурхай явуулах зорилгоор 20мкв бүхий 2 өрөөг зориулалтын дагуу тохижуулж, шаардлагатай мэдээллийн технологийн техник хэрэслээр ханган ашиглалтад оруулсан.

ХЗДХС-ын 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/128 тоот тушаалын дагуу Төсвийн хяналтын нэгдсэн платформыг нэвтрүүлэх зорилгоор Даталанд ХХК-ийн холбогдох мэргэжилтнүүдтэй байгууллагын санхүү, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын чиглэлээр төсвийн хяналтын бий болгох, хяналтын тоо мэдээг холбогдох удирдлагуудад цахим хэлбэрээр танилцуулах системийн баримт бичгийг боловсруулж, систем гүйцэтгэх гэрээг 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 09 тоот байгуулсан.

Технологийн дэвшлийг байгууллагад нэвтрүүлэх ажлын хүрээнд УБЕГ-тай хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих анги, нэгжийн байрлалд байгууллагад ажиллаж байгаа нийт алба хаагчдад иргэний тоон гарын үсэг олгохоор 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 05/1080 тоот албан бичгээр хорих анги, байгууллагад чиглэл хүргүүлэн эхний үе шатыг 2022 оны II улиралд эхлүүлэн 2837 алба хаагчийг хамруулсан, хоёрдугаар үе шатыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр шуурхай мэдээ хүргүүлэн 3246 алба хаагч буюу 100 хувь хамруулж ашиглалтын талаар заавар, зөвлөгөөг тухай бүр өгч сургалтыг явуулсан.

Мөн ял эдэлж буй хоригдлуудад иргэний тоон гарын үсгийг олгох зорилгоор ХЯЭА-ны Сургалт, нийгэм сэтгэл зүйн хэлтэстэй хамтран 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр шуурхай мэдээ хүргүүлсэн. 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн байдлаар 662 хоригдолд тоон гарын үсэг олгож ашиглалтын талаар заавар, зөвлөгөөг өгсөн бөгөөд олголтын ажил цаашид тогтмол үргэлжилж байна.

Байгууллагын хэмжээнд албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг инновацад суурилан хөгжүүлэх зорилгоор Edoc системийг нэвтрүүлэхээр 2022.07.18-07.22-ны өдрүүдэд нийт **1321** хэрэглэгчийг үүсгэж, ШШГЕГ-ын системийн админ **2** алба хаагч, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан **62** алба хаагч, систем ашиглах **964** алба хаагчийн сургалт, дадлага ажлыг 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс 27-ны өдрүүдэд, **95** удирдах алба хаагчийн сургалт, дадлага ажлыг 2022 оны 10 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулж,

байгууллагын хэмжээнд нийт **1123** алба хаагчдад систем ашиглалтын талаар сургалтыг зохион байгуулсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/239 тоот тушаалаар тус систем рүү шилжиж албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг бүрэн цахим хэлбэрт шилжсэн.

3.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/126 дугаар тушаалаар “ШШГБ-ын Жендэрийн асуудал хариуцсан дэд зөвлөл”-ийг шинэчлэн баталсан.

Тус зөвлөлийн 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан анги, байгууллагад албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг хагас, бүтэн жилээр ирүүлэх үүрэг өгсөн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа **55** анги, байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар арга хэмжээ оруулсан.

Хууль зүй, дотоод хэргийн яам болон Жендэрийн үндэсний хорооноос хамтран зохион байгуулж буй “Харилцан хүндэтгээ”, “Хамтдаа үлгэрлээ” аяны хүрээнд постер, шторк бэлтгэн олон нийтэд хүргэхэд тус постерыг нийт **150** удаа хуваалцаж, **700** удаа хандалт хийсэн байна.

“Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 10 хоногийн аян”-ны хүрээнд “НАНДИН БҮХНЭЭ ХАМГААЛЬЯ–ӨӨРИЙГӨӨ, ГЭР БҮЛЭЭ, ОРЧИН ТОЙРНОО” хэмээх уриалгад нэгдэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “Жендэр суурилсан хүчирхийлэл, Ажлын байран дахь бэлгийн дарамт” сэдвээр ДХИС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, доктор /Ph.D/, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа Ж.Нямдуламаар алба хаагчдад сургалт зохион байгуулж, 12 асуулга бүхий санал асуулга явуулан, “Цагаан тууз” зүүж хүчирхийллийн эсрэг дуу хоолойгоо нэгтгэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, байгууллагуудын хөдөлмөрийн дотоод журамд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн 11.4.1 дэх заалт/Ажлын байрны бэлгийн дарамт/ туссан эсэхэд хийсэн дүн шинжилгээг танилцуулах хэлэлцүүлэгт нийт **84** удирдах албан тушаалтанг хамруулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын гэр бүлийн гишүүдээс Монгол цэргийн нэгдсэн холбооны дэргэдэх “Бид мартаагүй” эмэгтэйчүүдийн клубээс Худалдаа хөгжлийн дээд сургуулийн дэргэдэх “Мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төв”-д суралцах хүсэлт гаргасан **29** иргэнийг хамруулахаар тогтож, урилгыг гардуулсан.

Тайлант хугацаанд “Жендэрийн эрх тэгш байдал, хүний эрх”, “Ажлын байран дахь жендэр”, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”, “Жендэрт суурилсан хүчирхийлэл”, “Гэр бүлийн хүчирхийлэл”, Гэмт хэрэг ба зөрчил”, “Хүний эрх ба Жендэрийн тэгш байдал”, “Ажлын байрны бэлгийн дарамт”, “Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал”, “Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, үл тэвчих орчинг бүрдүүлэх”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Жендэрийн хэвшмэл ойлголт”, “Жендэрийн тухай ойлголт, хүйсийн ялгаатай байдлыг хүндлэх соёлыг төлөвшүүлэх нь”, “Гэр бүлийн харилцаа”, “Байгууллагын үйл ажиллагаанд жендэрийн дүн шинжилгээ хийх нь”

сэдэвт сургалтуудыг 407, 413, 415, 419, 421, 423, 427, 429, 433, 437 дугаар нээлттэй, хаалттай хорих ангиуд, Дорноговь, Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл аймаг дахь ШШГГ, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь ШШГХ, СМДӨАЭХХГ-д тус тус зохион байгуулсан байна.

Мөн Мэргэжлийн сургалт-Үйлдвэрлэлийн төв нь Удирдлагын академиас зохион байгуулсан “Ахисан түвшний Жендэрийн дүн шинжилгээ” сургалтад 9 алба хаагч хамруулсан байна.

3.3. 2022 оны жилийн эцсийн байдлаар 439 алба хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авилгатай тэмцэх газраар хянуулж, дүгнэлт гаргуулан 382 алба хаагчийг албан тушаалд томилж, тодорхой шалтгааны улмаас албан тушаалд томилогдоогүй 11, дүгнэлтийн хариу ирээгүй хянагдаж байгаа 46 алба хаагч байна.

3.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд, олон нийтийг хэрэгцээт мэдээ, мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх, алба хаагчдын ажил албаны онцлог, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нэвтрүүлэг, сурвалжилга, ярилцлага, богино хэмжээний видео, шторк, постер зэргийг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сошиал орчинд түгээн ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдлыг хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, олон нийтэд хүргэх хүрээнд тайлант хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Байгууллагын цахим хуудсыг шинэчлэлтийг хийж дуусган, туршилтын хэлбэрээр [www.uzesgelen.cd.gov.mn](http://www.uzesgelen.cd.gov.mn) хаягт байршуулж, 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс үндсэн цахим хуудасны срапел-тай холбосон. Мөн нийт хорих анги, байгууллагын 63 цахим хуудсыг шинэчлэн байршуулж, мэдээ, мэдээлэл нийтлэн байршуулах тухай сургалт зохион байгуулсан.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нийт 54 анги, байгууллага, салбар нэгжийг албан ёсны нэршилтэй фэйсбүүк хуудастай болгож, тухайн фэйсбүүк хуудсыг хөтлөн ажиллуулах зөвлөмжийг 2022 оны 02 дугаар 11-ний өдрийн 05/161 дугаар албан бичгээр хүргүүлж, анги, байгууллага, салбар нэгжийн фэйсбүүк хуудасны үйл ажиллагааг жигдрүүлэн, баяжилт, хөтлөлтөд хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын [www.cd.gov.mn](http://www.cd.gov.mn) сайтад 182, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага пэйж хуудаст 404 мэдээ, мэдээллийг байршуулж ажилласан.

Мөн мэдээ, мэдээллийг мэргэжлийн түвшинд бэлтгэн, төрлийг нэмэгдүүлж, арга хэлбэрийг сайжруулах ажлын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвөөс дотооддоо 38 постер, 10 видео мэдээ, 10 шторк, 6 подкаст, 12 фото сурвалжилга, 1 ярилцлага, 1 удаагийн шууд дамжуулалт тус тус бэлтгэн олон нийтэд хүргэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын албан ёсны [www.cd.gov.mn](http://www.cd.gov.mn) сайтын хандалт 136,112 байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25631-ээр өссөн үзүүлэлттэй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан ёсны пэйж хуудас 40391 дагагчтай байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10241-ээр өссөн үзүүлэлттэй байна.

Байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлын хүрээнд телевизийн нэвтрүүлэг 3, ярилцлага 2, мэдээ 44, сонинд сурвалжилга 2, ярилцлага 4, мэдээ 34, радиод ярилцлага 2, сайтад 9, сурвалжилга, 233 мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчтай холбоотой 11 удаагийн тодруулга, залруулга мэдээллийг нийт 52 сонин, сайтад нийтэлж ажилласан.

Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 2022 онд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулаагүй.

#### **4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар зөвлөгөө өгч, ажилласан байдал, үр дүн**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжүүдийн “Сахилга, ёс зүйн хороо”-д нь 2022 онд алба хаагчдын дунд сургалт зохион байгуулах, тэдний албан үүрэг гүйцэтгэлт, сахилга, ёс зүй, хариуцлага, сонор сэрэмжийн байдалд хяналт тавин, илэрсэн зөрчлийг засуулахаар зөвлөмж, дүгнэлт өгөх зэргээр дараах онцлох арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Үүнд;

- 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг: 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр ДХИС-ийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, хошууч Б.Галбадрах, Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах багш, хошууч Э.Өнөболд нарыг урин ирүүлж, “Ажлаас халшрах хам шинж” “Хорих ял эдлүүлэх ажиллаганы олон улсын хэм хэмжээ” сэдвээр,

- 405 дугаар хаалттай /тусгай нэгж/ хорих анги: 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр шинэчлэн батлагдсан “Цэргийн нийтлэг дүрэм”-ээр,

- 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги: 2022 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн “Алба хаагчдын сахилга хариуцлага, сонор сэрэмж, цэргийн дүрэмт хувцасыг өмсөж хэрэглэх, цэрэгжилч, жагсаалч байдлыг дээшлүүлэх нь” 21 хоногийн аянг зохион байгуулсан ба аяны хүрээнд “Ногоон” дохиогоор ажиллуулж, цэргийн дүрэмт хувцас, аранзанд үзлэг хийж, “Цэргийн нийтлэг дүрэм”-ээр,

-Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь ШШГХ-413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги: “ШШГБ-ын алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Зөрчлийн тухай хууль”, Төв аймаг дахь ШШГГ нь “Авлигын эсрэг гэмт хэрэг”, “Авлигыг оношлох нь, илрэх хэлбэр” сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан. Мөн тус хорих анги нь “Цэрэгжилт, жагсаалч байдлыг дээшлүүлэх” 1 сарын аяныг 2022 оны 04 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 01 хүртэл, “Офицрийн манлайлал” нэг сарын аяныг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс, “Сонор” нэг сарын аяныг 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс тус тус зохион байгуулж, дүгнэжээ. Цагдаагийн хэлтсээс сар бүр алба хаагчдын гаргасан зөрчлийн судалгааг авч ажиллаж байна.

- 415 дугаар нээлттэй, хаалттай хорих анги: Сахилга, ёс зүйн салбар хороо нь 7 дугаар сард нэр бүхий 2 алба хаагчийн зөрчлийг ангийн даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, малын хэсэгт үүрэг гүйцэтгэх үедээ архи уусан хамгаалалтын ажилтан, ахлах ахлагч Ц.Отгонпүрэвт ангийн даргын тушаалаар

албан тушаалын цалингийн хэмжээг 2 сарын хугацаагаар 20 хувь, хамгаалалтын ажилтан, ахлах ахлагч Б.Отгонбаяр нь албаны бэлэн байдал шалгахад ирээгүй, аранзны бүрдэл хангаагүй зөрчил гаргасан тул мөн албан тушаалын цалинг 1 сарын хугацаагаар 20 хувиар тус тус бууруулах сахилгын шийтгэл ногдуулжээ.

Тус анги долоо хоног бүрийн Даваа гарагийн албаны нэгдсэн хуралд алба хаагчдад сахилга, хариуцлагаа дээшлүүлж, ёс зүйн зөрчил, дутагдалгүй ажиллах талаар үүрэг, чиглэлийг амаар өгч, хурлын тэмдэглэл болон бусад байдлаар баримтжуулж ажиллан хэвшжээ.

- 417 дугаар нээлттэй хорих анги: Алба хаагчийн сахилга ёс зүй, харилцааны соёл, цэрэгжилч жагсаалч байдлыг дээшлүүлэх зорилгоор “Цэргийн жавхаа 3” аяныг зохион байгуулсан ба тус аяны хүрээнд спортын уралдаан тэмцээн, урлагын үзлэг, ажил мэргэжилтэй холбоотой арга хэмжээ, цэргийн хэргийн мэдлэг сайжруулах сургалт зохион байгуулсан.

- 421 дүгээр нээлттэй хорих анги: 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газрын 3 дугаар хэлтэстэй хамтран эрүү болон зөрчлийн хуулиудаар сургалт орсон.

- 439 дүгээр хаалттай хорих анги: 2022 оны 1, 2 дугаар улирлын “Ёс зүйтэй алба хаагч”-ийг шалгаруулж, шалгарсан алба хаагчийн зургийг Ёс зүйн хүндэт самбарт, мөн сахилга, ёс зүйн талаар мэдээлэл, шторкууд бэлтгэн “Хэрэглэгчийн булан”-д тус тус байршуулжээ.

- Хэнтий аймаг дахь ШШГ-419 дүгээр нээлттэй хорих анги: 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Хэнтий аймгийн Хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжлийн газрын сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, А.Оюунтуяа нь “Хүүхдийн эрх, эцэг, эхийн хайр халамж” нэртэй сургалт орсон.

- Орхон аймаг дахь ШШГГ-437 дугаар нээлттэй хорих анги: Сахилга, ёс зүйн салбар хороо нь 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдөр тус аймгийн Цагдаагийн газартай хамтран замын хөдөлгөөний аюулгүй байдал, архидан согтуурахын хор уршиг сэдвээр сургалт зохион байгуулсан.

- Дархан-Уул аймаг дахь ШШГГ-445 дугаар нээлттэй хорих анги: Алба хаагчдын дунд “Мэдлэг, ур чадвар”-ын болзолт уралдаан зарласан. Ингэснээр сар, улирал бүр албаны сургалт болон бие бялдар, нормативын шалгалт авч, үр дүнг тооцож ажилласан.

- Ховд аймаг дахь ШШГ-457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги: Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, ажлын цаг ашиглалт, ажлын гүйцэтгэлийн чанар, цэргийн дүрэмт хувцсыг дүрмийн дагуу цэвэр, үзэмжтэй хэрэглэх, цэргийн нийтлэг дүрмүүдийг хангуулах зорилгоор 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл 1 сарын аян зохион байгуулан ажиллажээ.

- Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдөр бие бүрэлдэхүүний сахилга хариуцлага, ёс зүй, ажил хэргийн мэдлэг, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн ахлах мэргэжилтэн Х.Соёлмааг урин ирүүлж, “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” сэдвээр 2 цагийн сургалт оруулсны

зэрэгцээ шинээр томилогдсон алба хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын түүхэн замнал, ахмад үеийнхний ажлын арга барил, туршлагаас суралцаж, ажил хөдөлмөртөө уялдуулан хэрэгжүүлэх, цаашид тогтвор суурьшилтай ажиллах урам зоригийг бий болгох зорилгоор уулзалт, ярилцлага арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд уулзалт арга хэмжээнд тус газрын ахмад настан, бэлтгэл ахмад Б.Наранбаатар, бэлтгэл ахлах ахлагч Ч.Баярсайхан нар “Зөрчил надаас шалтгаална” сэдэвт илтгэл, ярилцлага хийсэн.

Уулзалт ярилцлагад шинээр томилогдсон 9 алба хаагч хамрагдсан байна.

Түүнчлэн тус газар нь алба хаагчийн сахилга батыг сайжруулах, албаны бэлэн байдлыг хангах зорилгоор “Шинийг санаачлан манлайлагч баг”, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь ШШГХ “Сахилга ёс зүй, цэргийн хэргийн мэдлэг, цэрэгжилч, жагсаалч байдлыг дээшлүүлэх”, Баривчлах төв “Бид цэргийн алба хаагч”, “Сахилга хариуцлага, сонор сэрэмжийг дээшлүүлэх нь”, “Тамхигүй орчин”, СМДӨАЭАХХГ “Цэрэгжилч, жагсаалч байдлыг сайжруулах” 1 сарын аян тус тус зохион байгуулсан байна.

-Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: “Сахилга, ёс зүйн салбар хороо” нь 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн Сүхбаатар аймаг хариуцсан нарийн бичгийн дарга С.Баянмөнхийг урьж “Төрийн албан хаагчийн сахилга, ёс зүйн хэм хэмжээ” сэдвээр 1 цагийн, нийт алба хаагчдыг авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх ерөнхий газарт хүсэлт гаргаж 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр “Авлигын ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх” сэдвээр цахим сургалтыг зохион байгуулжээ.

Ирүүлсэн тайланг нэгтгэхэд 2022 оны жилийн эцсийн байдлаар харьяа нэгжүүдийн Салбар ёс зүйн хороо нийт 455 удаа хуралдсан нь өмнөх оны /216 удаа/ мөн үетэй харьцуулахад 53 хувиар өссөн байна. Үүнээс 433 дугаар хаалттай хорих анги 18, Сүхбаатар аймаг дахь ШШГГ 18, Дундговь аймаг дахь ШШГГ 16 удаа хуралдсан бол бусад хорих анги, байгууллагууд 8-10 удаа хуралдсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар алба хаагчдаас давхардсан тоогоор нийт 992 зөрчил гарсан байна.

Харин 2022 оны жилийн эцсийн байдлаар эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан, албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн давхардсан тоогоор нийт 393 алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан нь өмнөх оны /373/ мөн үетэй харьцуулахад 20-иор буюу 5.1 хувиар өсчээ.

2022 оны 10 сарын байдлаар алба хаагчийн зан харилцаа, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хариуцлагагүй хандсан, албан тушаалын тодорхойлолтод заасан үүргээ бүрэн биелүүлээгүй, чирэгдэл учруулсан талаар Сахилга, ёс зүйн хороонд 4, салбар хороонд 3, нийт 7 өргөдөл, гомдол гарсныг тус тус шалган шийдвэрлэж ажиллалаа

### **Дүгнэлт:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон

тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, зааврыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус байгууллага нь иргэн, алба хаагчдын сонгон шалгаруулах, тэдгээрийн мэдлэг боловсрол, ур чадвар, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, тэдний идэвх санаачилга, урам зоригийг өрнүүлэхэд чиглэсэн удирдлага зохион байгуулалтын олон талт арга хэмжээг тодорхой төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллаж байна.

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ